



ИНД - 61

Иргэний Нисэхийн Дүрэм

Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-61 нь нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн нөхцөл, эрх, хязгаарлалт болон сурагч-нисгэгчид хамаарах нөхцөлийг багтаасан, нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл олгох, эзэмших болон сурагч нисгэгчтэй холбоотой шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-61-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-61, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2001 оны 10 сарын 01
Нэмэлт, өөрчлөлт 1	2002 оны 9 сарын 17
Нэмэлт, өөрчлөлт 2	2005 оны 9 сарын 14
Нэмэлт, өөрчлөлт 3	2010 оны 4 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 4	2018 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-61-ийн шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 61 Amend.12-т үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	7
61.1. Зорилго	7
61.3. Тодорхойлолт.....	7
61.5. Нисгэгчийн үнэмлэх болон зэрэглэлд тавих шаардлага	7
61.7. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон зөвшөөрөл	10
61.9. Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг баталгаажуулах зөвшөөрөл.....	11
61.11. Хүсэлт гаргах болон мэргэшлийн шаардлага	11
61.13. Нөөц.....	12
61.15. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хугацаа.....	12
61.17. Бичгийн шалгалт - урьдчилсан шаардлага болон дүн	12
61.19. Бичгийн шалгалт - хориглох зүйлс.....	12
61.21. Нислэгийн шалгалт	13
61.23. Нөөц.....	14
61.25. Нислэгийн сургалт болон шалгалт - ерөнхий шаардлага	14
61.27. Шалгагч-нисгэгчийн үүрэг.....	15
61.29. Нисгэгчийн дэвтэр - ерөнхий шаардлага	15
61.31. Нисгэгчийн дэвтэр - нислэгийн цаг тооцох.....	18
61.33. Нисгэгчийн дэвтэр - дадлагажуурын цаг тооцох.....	20
61.35. Эрүүл мэндийн шаардлага.....	20
61.37. Нислэгийн туршлага хадгалах	21
61.39. Хоёр жилийн нислэгийн үнэлгээ	23
61.41. Доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл ашиглах	24
61.43. Мэргэжлийн ур чадварын шалгалт	24
В Бүлэг - Агаарын хөлгийн маягийн зэрэглэл	25
61.51. Зорилго	25
61.53. Нөхцөл хангах шаардлага	25
61.55. Зэрэглэл олгох	26
61.57. Анхдагч маягийн эрх.....	27
С Бүлэг - Сурагч-нисгэгч	27
61.101. Зорилго	27
61.103. Ерөнхий зүйл.....	27
61.105. Бие даасан нислэгийн шаардлага	27
61.107. Хязгаарлалт	29
Д Бүлэг - Хувийн нисгэгчийн үнэмлэх	30
61.151. Зорилго	30
61.153. Нөхцөл хангах шаардлага	30
61.155. Эрх, хязгаарлалт.....	32
61.157. Хүчинтэй байх шаардлага	32
Е Бүлэг - Коммерийн нисгэгчийн үнэмлэх	33
61.201. Зорилго	33
61.203. Нөхцөл хангах шаардлага	33
61.205. Эрх, хязгаарлалт.....	34
61.207. Хүчинтэй байх шаардлага	35

F Бүлэг - Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх	35
61.251. Зорилго	35
61.253. Нөхцөл хангах шаардлага	35
61.255. Эрх	37
61.257. Хүчинтэй байх шаардлага	37
G Бүлэг - Багш-нисгэгчийн зэрэглэл	37
61.301. Зорилго	37
61.303. Нөхцөл хангах шаардлага	37
61.304. Зэрэглэл олгох	41
61.305. Эрх, хязгаарлалт	42
61.307. Хүчинтэй байх шаардлага	45
61.309. E-Категорийн багш-нисгэгчийн шилжилтийн зохицуулалт	46
H Бүлэг - Сонирхогч нисгэгчийн үнэмлэх	47
61.351. Зорилго	47
61.353. Тодорхойлолт	47
61.355. Нөхцөл хангах шаардлага	47
61.357. Эрх, хязгаарлалт	48
61.359. Сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн эрүүл мэндийн нөхцөлийн өөрчлөлт ⁴⁹	
61.361. Хүчинтэй байх шаардлага	49
I Бүлэг - [Нөөц]	49
J Бүлэг - [Нөөц]	49
K Бүлэг - [Нөөц]	49
L Бүлэг - Аэробатикийн зэрэглэл	50
61.551. Нөхцөл хангах шаардлага	50
61.553. Зэрэглэл олгох	51
61.555. Эрх, хязгаарлалт	51
61.557. Хүчинтэй байх шаардлага	51
M Бүлэг - Глайдер чирэх зэрэглэл	52
61.601. Нөхцөл хангах шаардлага	52
61.603. Зэрэглэл олгох	52
61.605. Эрх, хязгаарлалт	53
61.607. Хүчинтэй байх шаардлага	53
N Бүлэг - Шүхэр хаях зэрэглэл	53
61.651. Нөхцөл хангах шаардлага	53
61.653. Зэрэглэл олгох	54
61.655. Эрх, хязгаарлалт	54
61.657. Хүчинтэй байх шаардлага	54
O Бүлэг - ХАА-н зэрэглэл	55
61.701. Нөхцөл хангах шаардлага	55
61.703. Зэрэглэл олгох	56
61.705. Эрх, хязгаарлалт	56

61.707.	Хүчинтэй байх шаардлага	57
61.709.	ХАА-н зэрэглэлийн шилжилтийн нөхцөл.....	58
61.710.	Баталгаажуулах зөвшөөрөл.....	58
ОА Бүлэг - Агаараас бордоо цацах зэрэглэл		59
61.711.	Нөхцөл хангах шаардлага	59
61.713.	Зэрэглэл олгох	59
61.715.	Эрх, хязгаарлалт.....	60
61.717.	Хүчинтэй байх шаардлага	60
61.719.	ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн зохицуулалт	60
ОВ Бүлэг - Агаараас шингэн цацах зэрэглэл		60
61.721.	Нөхцөл хангах шаардлага	60
61.723.	Зэрэглэл олгох	61
61.725.	Эрх	61
61.727.	Хүчинтэй байх шаардлага	61
61.729.	ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн зохицуулалт	62
ОС Бүлэг - Агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл		62
61.731.	Нөхцөл хангах шаардлага	62
61.733.	Зэрэглэл олгох	62
61.735.	Эрх	63
61.737.	Хүчинтэй байх шаардлага	63
61.739.	ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн нөхцөл.....	63
Р Бүлэг - Нисгэгчийн химийн зэрэглэл		64
61.751.	Нөхцөл хангах шаардлага	64
61.753.	Зэрэглэл олгох	64
61.755.	Эрх	64
61.757.	Хүчинтэй байх шаардлага	64
Q Бүлэг - Хэрэглэлийн зэрэглэл		65
61.801.	Нөхцөл хангах шаардлага	65
61.803.	Зэрэглэл олгох	67
61.805.	Эрх, хязгаарлалт.....	67
61.807.	Хүчинтэй байх шаардлага	68
R Бүлэг - Нөөц		69
S Бүлэг - Шалгагч-нисгэгчийн зэрэглэл.....		69
61.901.	Нөхцөл хангах шаардлага	69
61.903.	Зэрэглэл олгох	70
61.905.	Эрх, хязгаарлалт.....	70
61.907.	Хүчинтэй байх шаардлага	72
61.909.	Мөрдөгдөж байгаа дүрмийн заалтыг хүчингүй болгох болон хадгалах	72

А Бүлэг - Ерөнхий зүйл

61.1. Зорилго

(а) Энэ Дүрэм нь:

- (1) нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон баталгаажуулах зөвшөөрөл олгоход тавих нөхцөл хангах шаардлага;
- (2) агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавих нөхцөл хангах шаардлага;
- (3) агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийн тулд нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмших шаардлагатай этгээдийн дагаж мөрдөх нөхцөл;
- (4) нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон баталгаажуулах зөвшөөрлийн эрх, хязгаарлалтыг тогтооно.

61.3. Тодорхойлолт

О, ОА, ОВ болон ОС Бүлгийн зорилгод нийцүүлэн энэ Дүрэмд -

Ур чадвараа амжилттай шалгуулах гэж, зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч, эсхүл зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн дагуу зөвшөөрөгдсөн холбогдох үйл ажиллагааг гүйцэтгэх хангалттай мэдлэг болон ур чадвараа шалгуулах зорилгоор мэргэшсэн холбогдох шалгагч-нисгэгч, эсхүл багш-нисгэгчид 61.701, 61.707, 61.711, 61.717, 61.721, 61.727, 61.731 болон 61.737-гийн дагуу аман болон нислэгийн шалгалт өгөхийг ойлгоно.

61.5. Нисгэгчийн үнэмлэх болон зэрэглэлд тавих шаардлага

(а) **Нисгэгчийн үнэмлэх-Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын агаарын хөлөг:** Энэ зүйлийн (m), (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлтэй Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа агаарын хөлгийн нисгэгч нь тохирох, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмших үүрэгтэй ба тухайн үнэмлэхийг:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл
- (2) нисгэгчийг үнэмлэхжүүлэх гадаадын эрх бүхий байгууллагаас олгосон ба 61.9-ийн дагуу баталгаажуулах зөвшөөрөлтэй байна.

(b) **Нисгэгчийн үнэмлэх-Монгол Улсын гадна үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын агаарын хөлөг:** Энэ зүйлийн (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлтэй, Монгол Улсын гадна үйл ажиллагаа явуулж байгаа агаарын хөлгийн нисгэгч нь тохирох, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмших үүрэгтэй ба тухайн үнэмлэхийг:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл
- (2) тухайн агаарын хөлөг үйл ажиллагаа явуулж байгаа Улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн; эсхүл

(3) нисгэгчийг үнэмлэхжүүлэх гадаадын эрх бүхий байгууллагаас олгосон ба 61.9-ийн дагуу баталгаажуулах зөвшөөрөлтэй байна.

(c) **Нисгэгчийн үнэмлэх - Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Гадаадын агаарын хөлөг:** Энэ зүйлийн (m), (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын агаарын хөлгийн нисгэгч нь дараах тохирох, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмших үүрэгтэй:

- (1) агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн; эсхүл
- (2) энэ Дүрмийн дагуу олгосон, Монгол Улсын нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэхийг агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрсөн.

(d) **Агаарын хөлгийн маягийн зэрэглэл:** Энэ зүйлийн (m)-ээс (q) хэсэг болон 61.57-д зааснаас бусад тохиолдолд, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, эсхүл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын агаарын хөлгийн нисгэгч нь тухайн агаарын хөлөгт, дараах хүчинтэй агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмших үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл
- (2) гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулах зөвшөөрөлд заасан; эсхүл
- (3) агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллагаас олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан; эсхүл
- (4) Монгол Улсын агаарын хөлөг үйл ажиллагаа явуулж байгаа улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллага олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан.

(e) [Нөөц]

(f) [Нөөц]

(g) [Нөөц]

(h) [Нөөц]

(i) [Нөөц]

(j) **Хэрэглэлийн зэрэглэл:** Энэ зүйлийн (m), (n)-д зааснаас бусад тохиолдолд, Монгол улсад ХНД-ээр үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг, эсхүл гадаадын агаарын хөлгийн нисгэгч нь дараах тохирох, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмших үүрэгтэй:

- (1) энэ Дүрмийн дагуу олгосон; эсхүл
- (2) гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулах зөвшөөрөлд заасан, эсхүл

(3) Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг үйл ажиллагаа явуулж байгаа Улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллага олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан, эсхүл;

(4) *хамааралгүй*

(5) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын бүртгэлтэй агаарын хөлгийн Бүртгэгч Улсын нисгэгчийг үнэмлэхжүүлэх эрх бүхий байгууллага олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан.

(к) **Багш-нисгэгчийн зэрэглэл:** Багш-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулах зөвшөөрөлд заасан тохирох, хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмших үүрэгтэй.

(л) **Шалгагч-нисгэгчийн зэрэглэл:** Шалгагч-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хавсаргасан ба 61.9-ийн дагуу олгосон баталгаажуулах зөвшөөрөлд заасан тохирох, хүчинтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших үүрэгтэй.

(м) Энэ Дүрмийн С Бүлгийн шаардлагыг хангаж байгаа сурагч-нисгэгчээс нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.

(н) Бөмбөлөг, глайдер, ханг-глайдер, микролайт, пара-глайдер, спортын хөнгөн агаарын хөлөг, эсхүл мото-глайдерын нисгэгчээс энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихийг шаардахгүй, хэрэв:

(1) тухайн нисгэгч нь агаарын хөлгөөр хөлс, эсхүл шан урамшуулалтай нислэг үйлдээгүй бол;

(2) тухайн нисгэгч нь ИНД-103, ИНД-104, эсхүл ИНД-106-гийн дагуу холбогдох нисгэгчийн болон үйл ажиллагааны шаардлагыг хангаж байгаа бол.

(о) Хэрэв тухайн багш нь ижил төстэй конфигурацитай нисэх онгоцны хувьд, агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг бол, хүчинтэй А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчээс ганц хөдөлгүүрт нисэх онгоцны нисгэгчийн үүрэг гүйцэтгэхэд агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.

(р) ИНД-19.405(1)-ийн дагуу туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн нисгэгчээс агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.

(q) Зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч зөвшөөрсөн бол, агаарын хөлгийн нисгэгчийг агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмших зорилгоор ур чадвараа шалгуулах, эсхүл дадлагын нислэг үйлдэх үедээ агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.

61.7. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон зөвшөөрөл

(a) Дарга, хууль болон энэ Дүрмийн холбогдох шаардлагын дагуу дараах маягийн нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл болон зөвшөөрлийг олгоно:

- | | |
|---|---|
| (1) сонирхогч нисгэгчийн үнэмлэх: | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг; |
| (2) хувийн нисгэгчийн үнэмлэх: | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг;
- Глайдер; |
| (3) коммерийн нисгэгчийн үнэмлэх: | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг;
- Бөмбөлөг;
- Глайдер; |
| (4) агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх: | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг; |
| (5) хэрэглэлийн зэрэглэл: | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг; |
| (6) А, В, С, D болон E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл: | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг; |
| (7) Шалгагч-нисгэгчийн зэрэглэл: | - Шугамын агаарын тээвэрлэгчийн;
- Ерөнхий зориулалтын нисэхийн;
- ХАА-н; |
| (8) баталгаажуулах зөвшөөрөл; | |
| (9) ХАА-н зэрэглэлийн Зэрэг-1 ба Зэрэг-2 | - Нисэх онгоц;
- Нисдэг тэрэг. |

(b) Энэ Дүрмийн холбогдох шаардлагын дагуу дараах зэрэглэлийг олгоно:

- (1) агаарын хөлгийн маягийн зэрэглэл;
- (2) аэробатикийн зэрэглэл;
- (3) глайдер чирэх зэрэглэл;
- (4) шүхэр хаях зэрэглэл;
- (5) [хүчингүй]

- (6) нисгэгчийн химийн зэрэглэл;
- (7) агаараас бордоо цацах зэрэглэл;
- (8) агаараас шингэн цацах зэрэглэл;
- (9) агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл.

61.9. Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг баталгаажуулах зөвшөөрөл

(a) Аливаа этгээд нь баталгаажуулах зөвшөөрөл авахын тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй хувийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) энэ зүйлийн (a)(1)-д шаардсан гадаадын нисгэгчийн үнэмлэхтэй холбоотой тохирох, хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;
- (3) тухайн хүсэлт гаргагч нь баталгаажуулах зөвшөөрлийн эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлээр унших, ярих, ойлгох болон харилцах хангалттай чадвартай байх;
- (4) Даргын шаардаж болох аливаа бичгийн болон нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.

(b) Баталгаажуулах зөвшөөрөлд дараах шаардлагыг заасан байх ёстой:

- (1) тухайн зөвшөөрлийн дуусах хугацаа нь олгосон өдрөөс хойш 6 сараас хэтрэхгүй байхыг;
- (2) тухайн эзэмшигчийн хэрэгжүүлж болох эрх нь гадаадын нисгэгчийн үнэмлэхээр олгосон эрхээс хэтрэхгүй байхыг.

(c) Баталгаажуулах зөвшөөрөл нь дараахаас бусад тохиолдолд, тухайн гэрчилгээнд заасан дуусах хугацаа хүртэл хүчинтэй хэвээр байна:

- (1) Дарга түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон; эсхүл
- (2) тухайн нисгэгчийн, гадаадын нисгэгчийн үнэмлэхний хугацаа дууссан, эсхүл тухайн олгосон Улс нь түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон.

61.11. Хүсэлт гаргах болон мэргэшлийн шаардлага

(a) Энэ Дүрмийн дагуу Даргын олгох нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлтийг холбогдох САА маягтын дагуу гаргах ёстой.

(b) Энэ Дүрмийн дагуу нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийн хүрээнд үүрэг хариуцлагаа бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлээр унших, ярих, ойлгох болон харилцах хангалттай чадвартай байх үүрэгтэй.

(c) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь холбогдох Бүлгийн нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшихэд тавих нөхцөл хангах шаардлагыг бүрэн хангасан байх үүрэгтэй.

61.13. Нөөц**61.15. Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэлийн хугацаа**

(a) Энэ Дүрмийн дагуу олгох нисгэгчийн үнэмлэхийг тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн насан туршид олгоно.

(b) Энэ зүйлийн (a)-ийг үл харгалзан, Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн аливаа нөхцөлд, Дарга нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийг түр хугацаагаар олгож болно.

61.17. Бичгийн шалгалт - урьдчилсан шаардлага болон дүн

(a) Энэ Дүрэмд шаардсан бичгийн шалгалт өгөх хүсэлт гаргагч нь дараах нотлох баримтыг үзүүлсэн байх үүрэгтэй:

(1) Монгол Улсын иргэний үнэмлэх; эсхүл

(2) Монгол Улсын жолооны үнэмлэх; эсхүл

(3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, фото зураг бүхий дүйцэх бусад бичиг баримт.

(b) Энэ Дүрэмд шаардсан бичгийн шалгалт өгөх хүсэлт гаргагч нь бичгийн шалгалтдаа тэнцэхийн тулд боломжит дүнгийн 70%-иас доошгүйг авсан байх үүрэгтэй.

(c) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл хэрэглэлийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь тухайн заасан үнэмлэх, эсхүл хэрэглэлийн зэрэглэлийн хувьд, шаардлагатай зөвшөөрөгдсөн бүх бичгийн шалгалтыг тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн бичгийн шалгалтын кредит цуглуулах анхны шалгалт өгснөөс хойш 3 жилийн дотор амжилттай өгсөн байх.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан бичгийн шалгалтын кредит нь:

(1) хувийн нисгэгчийн үнэмлэх, коммерийн нисгэгчийн үнэмлэх, сонирхогч нисгэгчийн үнэмлэх болон хэрэглэлийн зэрэглэлийн хувьд, 3 жилийн хугацаанд хүчинтэй;

(2) агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний хувьд, 10 жилийн хугацаанд хүчинтэй (гэхдээ агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний нисэхийн хууль, дүрмийн шалгалтад тэнцсэн дүн нь 5 жилээс хэтрэхгүй байх ёстой).

(e) Бичгийн шалгалтад 3 сарын дотор 3 удаа хангалтгүй дүн үзүүлсэн этгээд нь сүүлчийн шалгалтыг амжилтгүй өгсөн өдрөөс хойш 3 сарын хугацаанд тухайн сэдвээр шалгалтад орохгүй.

61.19. Бичгийн шалгалт - хориглох зүйлс

(a) Энэ Дүрэмд шаардсан бичгийн шалгалтын үед этгээд нь дараах аль нэг үйлдлийг хийх, эсхүл завдах, эсхүл бусдыг ийм үйлдэл хийхэд хүргэхийг хориглоно:

(1) бусад этгээдээс хуулах;

(2) аливаа зөвшөөрөгдөөгүй мэдээллийн эх үүсвэр ашиглах;

- (3) шалгалт авч байгаа этгээдээс өөр бусад этгээдтэй ямар нэг замаар харьцах;
- (4) бусад этгээдийн өмнөөс шалгалт өгөх;
- (5) шалгалт авч байгаа этгээд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, бичгийн, эсхүл хэвлэмэл материалыг шалгалтын өрөөнөөс авч гарах;
- (6) шалгалтын өрөөнд зөвшөөрөгдөөгүй материал авч орох;
- (7) тухайн шалгалтын үед түгээсэн цахим, бичгэн, эсхүл хэвлэмэл материалыг аливаа арга хэлбэрээр, эсхүл хэрэгсэл ашиглан хуулбарлах.

(b) Хэрэв, этгээд нь энэ зүйлийн (a)-д хориглосон үйлдлийг хийсэн, эсхүл бусад этгээдийг ийм үйлдэл хийхэд хүргэсэн байж болох бодит үндэслэл байна гэж Дарга үзвэл, Дарга тухайн этгээдийн шалгалтын үр дүнг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн дараах шийдвэр гарах хүртэл түдгэлзүүлж болно:

- (1) шалгасны дараа, хэрэв байгаа бол, энэ зүйлийн (c)-гийн дагуу авч болох Даргын тогтоосон арга хэмжээ; эсхүл
- (2) хэрэв тухайн этгээд Даргад бичгээр хүсэлт гаргасан бол, 61.19(a)-ийг зөрчсөн байж болох аливаа үйлдлийг шалгасны дараа, хэрэв байгаа бол, энэ зүйлийн (c)-гийн дагуу авч болох Даргын тогтоосон арга хэмжээ.

(c) Хэрэв, этгээд нь энэ зүйлийн (a)-д хориглосон үйлдлийг хийсэн, эсхүл бусад этгээдийг ийм үйлдэл хийхэд хүргэсэн байж болох бодит үндэслэл байна гэж Дарга үзвэл, дараах арга хэмжээг авч болно:

- (1) тухайн этгээдийн шалгалтын үр дүнг хүчингүйд тооцох;
- (2) тухайн этгээдийг 12 сараас ихгүй тогтоосон хугацаанд аливаа шалгалтад оруулахгүй байх.

(d) Дарга, энэ зүйлийн (b), эсхүл (c)-гийн дагуу арга хэмжээ авахын өмнө, энэ зүйлийн (a)-д заасан хориглосон үйлдлийг хийсэн байж болох мэдээллийн дэлгэрэнгүйг тухайн этгээдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

(e) Хэрэв Дарга, энэ зүйлийн (c)-гийн дагуу арга хэмжээ авахаар зорьж байгаа бол, тухайн зорьсон арга хэмжээг хуулийн хүрээнд авна.

61.21. Нислэгийн шалгалт

(a) Нислэгийн шалгалт өгөх хүсэлт гаргагч нь дараах баримтыг бүрдүүлсэн байх үүрэгтэй:

- (1) 61.17(a)-д заасны дагуу таних шаардлага хангасан нотлох баримт;
- (2) тухайн шалгуулах үнэмлэх, эсхүл зэрэглэлд шаардсан нислэгийн дадлага туршлагыг нотлох баримтыг агуулсан, тухайн өдрийн байдлаар бүрэн гүйцэд бөглөж, нэгтгэн баталгаажуулсан нисгэгчийн дэвтэр;
- (3) шалгуулах тухайн үнэмлэхэнд хамаарах, хүчинтэй ЭМГ;
- (4) шалгуулах тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн бичгийн шалгалтын кредит;

- (5) А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчээр баталгаажуулсан, энэ зүйлийн (а)(4)-т шаардсан бичгийн шалгалтын кредитийн “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-г бичгийн шалгалт тус бүрээр гаргаж, дэлгэрэнгүй заагдсан дутуу мэдлэгийн сэдвийг нөхөж суралцсан баримт,
- (6) хувийн нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалтаас бусад тохиолдолд, нислэгийн шалгалтад ашиглаж байгаа тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг байх.
- (b) Энэ Дүрмийн дагуу шаардсан нислэгийн шалгалт нь, тухайн шалгалтыг амжилттай өгсөн өдрөөс хойш 3 сарын хугацаанд хүчинтэй байна.
- (c) [Хүчингүй]

61.23. Нөөц

61.25. Нислэгийн сургалт болон шалгалт - ерөнхий шаардлага

- (a) Энэ Дүрмийн дагуу шаардсан нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:
- (1) тухайн шаардсан нислэгийн шалгалт авах зорилгод тохирох агаарын хөлгийг бэлтгэх;
 - (2) тухайн нислэгийн шалгалтын өмнө болон дараа нислэгийн яриа хийхэд тохиромжтой, тусгаарлагдсан өрөөгөөр хангах.
- (b) Энэ Дүрэмд шаардсан аливаа нислэгийн шалгалт, эсхүл хосолсон нислэгийн зааварчилгааг дараах байдлаар тоногдсон агаарын хөлгөөр гүйцэтгэх ёстой:
- (1) бүрэн ажиллагаатай хосолсон нислэгийн удирдлагатай;
 - (2) тухайн нислэгийн үед шалгуулахаар төлөвлөсөн маневрт зайлшгүй шаардлагатай, хоёр нисгэгчид харагдахуйц, хөндлөнгөөс харах харааны алдаагүй (parallax error) хэрэглэлтэй;
 - (3) нисэх багийн гишүүн бүрийн суудал нь хос мөрөвчит даруулга, эсхүл ганц хөндлөн мөрөвчит даруулгатай бүс;
 - (4) зөвшөөрөгдсөн маягийн дотоод холбооны төхөөрөмжтэй.
- (c) Нисгэгч нь дараахаас бусад тохиолдолд, ил харааны нислэгийн цаг уурын нөхцөлд (VMC) гүйцэтгэсэн тухайн хэрэглэлийн нислэгийн туршлагаа хэрэглэлийн зэрэглэл авах цагт, эсхүл хэрэглэлийн нислэгийн туршлага хадгалах шаардлагад оруулж тооцохгүй:
- (1) тухайн агаарын хөлөгт бүрэн ажиллагаатай хосолсон нислэгийн удирдлага суурилуулсан бол;
 - (2) тухайн нисгэгчийн хэрэглэлийн нислэгийн дадлага авах зорилгоор ашиглаж байгаа дуураймал хэрэглэлийн нислэгийн тоноглол нь хүлээн зөвшөөрөхүйц бол;

(3) аюулгүй байдлын нисгэгч (safety pilot) нь тухайн агаарын хөлөгт урд болон хоёр тал саадгүй харагдах жолоодлого бүхий нисгэгчийн суудалд суусан ба дараах бүх шаардлагыг хангасан бол:

- (i) хүчинтэй нисгэгчийн үнэмлэхтэй;
- (ii) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй;
- (iii) хэрэв агаарын хөлөг шөнийн цагаар нислэг үйлдэж байгаа бол, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй байх.

(d) Нисгэгч нь дараахаас бусад тохиолдолд, хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөлд (IMC) гүйцэтгэсэн хэрэглэлийн нислэгийн туршлагаа хэрэглэлийн зэрэглэл авах цагт, эсхүл хэрэглэлийн нислэгийн туршлага хадгалах шаардлагад оруулж тооцохгүй:

- (1) тухайн агаарын хөлөг нь ХНД-ийн нислэгт зөвшөөрөгдсөн,
- (2) хоёр нисгэгч нисэх шаардлагатай агаарын хөлөгт бүрэн ажиллагаатай хосолсон нислэгийн удирдлага суурилуулсан;
- (3) тухайн нисгэгч нь:
 - (i) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч; эсхүл
 - (ii) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл болон хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй хөлгийн даргын хяналтад хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа авч байгаа.

61.27. Шалгагч-нисгэгчийн үүрэг

Шалгагч-нисгэгч нь дараах нөхцөлд агаарын хөлгийн дарга байх үүрэгтэй:

- (1) хэрэглэлийн зэрэглэл анх олгох нислэгийн шалгалтын үед;
- (2) тухайн шалгагч-нисгэгч, аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн үед.

61.29. Нисгэгчийн дэвтэр - ерөнхий шаардлага

(a) Сурагч-нисгэгч болон энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах мэдээллийг агуулсан нисгэгчийн дэвтрийг тогтмол шинэчлэн нямбай хөтлөх үүрэгтэй:

- (1) тухайн нисгэгчийн нэр, агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн дэлгэрэнгүй мэдээлэл болон эзэмшиж байгаа гэрчилгээ, эрх болон зэрэглэл;
- (2) энэ зүйлийн (b)-д заасан дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан дараах тэмдэглэл:
 - (i) тухайн нисгэгч, агаарын хөлгийн нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэсэн нислэг бүрийн;

- (ii) нислэгийн цаг тооцох, эсхүл энэ Дүрэмд заасан нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хүчинтэй байх шаардлагыг хангах зорилгоор үйлдсэн дуураймал нислэг бүрийн,
- (3) дараах мэдээллийг багтаасан, нислэгийн шалгалт, нислэгийн үнэлгээ, ур чадварын шалгалт болон нисэх багийн ур чадварын шалгалт бүрийн тэмдэглэл:
- (i) тухайн нислэгийн зорилго;
 - (ii) тухайн нислэг үйлдсэн огноо;
 - (iii) нислэгийн шалгалт, нислэгийн үнэлгээ, ур чадварын шалгалт, эсхүл шалгалтын дуусах хугацаа;
 - (iv) нислэгийн шалгалт, нислэгийн үнэлгээ, ур чадварын шалгалт, эсхүл тухайн шалгалт авсан этгээдийн нэр, үйлчлүүлэгчийн дугаар болон гарын үсэг.
- (b) Тухайн нисгэгчийн дэвтэрт дараах нислэгийн болон хэрэглэлийн нислэгийн дэлгэрэнгүй мэдээллийг тэмдэглэдэг байх үүрэгтэй:
- (1) тухайн нислэг үйлдсэн огноо;
 - (2) агаарын хөлгөөр үйлдсэн нислэгийн хувьд:
 - (i) тухайн агаарын хөлгийн категори, маяг болон бүртгэлийн дугаар;
 - (ii) нислэгийн цаг;
 - (iii) дуураймал болон бодит хэрэглэлийн нислэгийн цаг;
 - (iv) хосолсон нислэгийн зааварчилгаа болон даргын дадлагыг багтаасан сургалтын аливаа төрөл;
 - (v) хэрэв хамааралтай бол, тухайн багш-нисгэгч, эсхүл аюулгүй байдлын нисгэгчийн (safety pilot) нэр;
 - (3) синтетик дадлагажуурт үйлдсэн нислэгийн хувьд:
 - (i) тухайн синтетик нислэгийн дадлагажуурын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (ii) хэрэглэлийн нислэгийн газрын цаг;
 - (iii) аливаа бусад газрын цаг;
 - (4) тухайн нисгэгчийн гүйцэтгэсэн дараах үүрэг:
 - (i) хөлгийн дарга (PIC);
 - (ii) хяналтад байгаа хөлгийн дарга (PIC/US), гэхдээ зөвхөн ИНД-135.505-ын шаардлага хангахаар;
 - (iii) хамтран нисгэгч;
 - (iv) сурагч-нисгэгч;
 - (5) нисэн гарсан газар, аливаа завсрын буулт болон нисэн хүрэх газрыг багтаасан тухайн нислэгийн зорилго;

- (6) тухайн нислэгийг өдөр, эсхүл шөнө алинд үйлдсэн болохыг;
 - (7) ХНД-ийн нислэгийн хувьд, тухайн хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын дагуу үйлдсэн нислэгийн тоо болон төрөл;
 - (8) сургалтын нислэгийн хувьд, тухайн сургалтын дасгалын дэлгэрэнгүй мэдээлэл;
 - (9) глайдерын нислэгийн хувьд, тухайн нислэгт хөөргөсөн арга;
 - (10) бөмбөлгийн нислэгийн хувьд, тухайн нислэгт ашигласан хийлэх арга, эсхүл төрөл.
- (c) Энэ зүйлийн (a)-д шаардсан нисгэгчийн дэвтэр нь дараах шаардлагыг хангах ёстой:
- (1) дэлгэрэнгүй мэдээллийг зөвшөөрөгдсөн дэвтэр дээр, арилдаггүй бэхээр бичих;
 - (2) нислэг бүрийг дараах байдлаар тэмдэглэх:
 - (i) тусад нь оруулах; эсхүл
 - (ii) компьютерт хөтөлдөг нислэгийн бүртгэлийг нисгэгчийн дэвтэрт байнга хадгалагдах хэлбэрээр оруулах; эсхүл
 - (iii) нэг өдөр үйлдсэн, дараалсан нислэгийн (series of flights) хувьд, хэрэв хөөрөлт, завсрын буулт болон хүрэх газрыг багтаасан нислэгүүдийн зорилго ижил бол, дараалсан нислэгүүдийг нэгтгэн нэмж нислэгийн нийт цагийг нэг мөрөнд дүгнэх;
 - (3) оруулсан бүх мэдээлэл үнэн зөв болохыг хуудас бүрийн доод хэсэгт тухайн нисгэгч баталгаажуулах;
 - (4) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь байнга хадгалах, хэрэв нисгэгчийн үнэмлэхийг хуулийн дагуу хүчингүй болгосон бол, хүчингүй болгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хадгалах үүрэгтэй.
- (d) Хэрэв энэ зүйлийн (c)(2)(ii)-ын дагуу компьютерт хөтөлсөн нислэгийн мэдээллийг нисгэгчийн дэвтэрт оруулсан бол, тухайн нисгэгч нь нислэгийн жагсаалт, нислэгийн нийлбэр цагийг энэ зүйлийн (b)-гийн дагуу үүрэг тус бүрээр нисгэгчийн дэвтэртээ бичиж тэмдэглэх үүрэгтэй.
- (e) Нисгэгчийн дэвтэрт алдаатай оруулсан бичилтийг зөвхөн дээр нь зураасаар дарж, зөв мэдээллийг араас нь, эсхүл шинэ мөрөнд нэмж оруулж болно.
- (f) Нисгэгчийн дэвтрийг Даргад ямар нэг шалтгаанаар хүргүүлэхийн өмнө нисгэгч нь:
- (1) хуудас бүрд оруулсан мэдээллийг багана бүрээр нэгтгэх;
 - (2) тухайн зориулагдсан зайд, нийт ниссэн цагийг тэмдэглэх;
 - (3) сүүлчийн тэмдэглэлийн дор тухайн тэмдэглэл нь үнэн зөв болохыг гарын үсэг зурж баталгаажуулах үүрэгтэй.

(г) Нисгэгчийн дэвтэрт оруулах мэдээлэл бүрийг, олон улсын агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд, тухайн нислэг дууссанаас хойш 14 хоногийн дотор, бусад тохиолдолд, 7 хоногийн дотор нисгэгч нь тухайн нислэгийн мэдээллийг заавал тэмдэглэх үүрэгтэй. Хэрэв нисгэгч нь нисгэгчийн дэвтрээ хадгалдаг үндсэн баазаас өөр газар үйл ажиллагаанд оролцож байгаа бол, үндсэн бааздаа буцаж ирснээс хойш 48 цагийн дотор мэдээллийг нисгэгчийн дэвтэртээ оруулдаг байх үүрэгтэй.

61.31. Нисгэгчийн дэвтэр - нислэгийн цаг тооцох

(а) Хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хамтран нисгэгчтэй ажиллахыг шаарддаг агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн бол, хамтран нисгэгчээр ниссэн цагийн 50%-иас ихгүйг агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх авахад шаардсан нийт нислэгийн цагийн туршлагад оруулж тооцох эрхтэй.

(б) Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь хамтран нисгэгчтэй ажиллахыг шаарддаг агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэн агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож, тухайн зорилгоор агаарын тээвэрлэгчийн томилсон хөлгийн даргын хяналтад хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн бол, энэхүү нислэгийн цагийг даргын дадлагын нислэгийн цагийн туршлагад тооцох эрхтэй, гэхдээ зөвхөн, хэрэв:

- (1) хамтран нисгэгч нь түлшний тооцоог багтаасан тухайн зорьж байгаа нислэгийн төлөвлөгөө, ачааллын хуудасны үнэн зөвийг шалгах хариуцлага хүлээсэн бол;
- (2) хамтран нисгэгч нь, үйл ажиллагааны заавар, эсхүл холбогдох бусад баримт бичигт агаарын тээвэрлэгчийн тогтоосон шалгалтын системийн дагуу, багийн гишүүн бүр бүх холбогдох шалгалтыг дараах нислэгийн үе шатанд гүйцэтгэснийг баталгаажуулсан бол:
 - (i) хөөрөлтийн өмнө;
 - (ii) хөөрөлтөд;
 - (iii) нислэгт;
 - (iv) буултад;
 - (v) аливаа онцгой нөхцөлд;
- (3) тухайн нислэгийн турш хамтран нисгэгч нь хөлгийн даргын гүйцэтгэж болох боломжит бүх үүрэг болон үйлдлийг хамтран нисгэгчийн суудлаас гүйцэтгэсэн бол, гэхдээ 6 цагаас дээш хугацаагаар үргэлжлэх нислэгийн хувьд, хамтран нисгэгчийг тухайн нислэгийн турш бүх үүргийг гүйцэтгэхийг шаардахгүй;
- (4) нислэгийг автомат хэлбэрээр гүйцэтгэж байгаа тохиолдолд, тухайн хамтран нисгэгч нь ашигласан нислэгийн болон газрын систем ашиглахтай холбоотой бүх шийдвэрийг гаргасан бол;
- (5) хамтран нисгэгч нь цаг уурын нөхцөл, холбоо болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын журмаас үүссэн аливаа хүндрэлийг шийдвэрлэснийг баталгаажуулсан бол;

(б) тухайн хамтран нисгэгчид хяналт тавихаар томилогдсон хөлгийн дарга хамтран нисгэгчийн дэвтэрт тухайн нислэгийн талаар зохих бичилтийг хийж баталгаажуулсан, эсхүл тээвэрлэгч тухайн нислэгийн тогтмол бүртгэлийг хөтөлсөн бол.

(с) Бодит, эсхүл хэрэглэлийн дуураймал нислэгийн нөхцөлд гадны хяналтын цэггүйгээр, зөвхөн хэрэглэл ашиглан агаарын хөлгийн удирдлагыг гардан гүйцэтгэж байгаа нисгэгч нь энэ аргаар цуглуулсан хэрэглэлийн нислэгийн цагийг дараах зорилгоор шаардсан нийт хэрэглэлийн нислэгийн цагийн туршлагад тооцох эрхтэй:

(1) нисгэгчийн үнэмлэхний эрэмбэ ахиулах; эсхүл

(2) хэрэглэлийн зэрэглэл эзэмших; эсхүл

(3) эзэмшиж байгаа хэрэглэлийн зэрэглэлийн туршлага хадгалах шаардлагыг хангах.

(d) Хөлгийн дарга, хэрэглэлийн нислэгийн цаг уурын бодит нөхцөлд, олон нисгэгчтэй агаарын хөлгийн нислэгийн удирдлагыг гардан гүйцэтгэж байгаа хамтран нисгэгчид хяналт тавьсан бол, тухайн цагийг хэрэглэлийн нислэгийн цагтаа оруулж тооцох эрхтэй.

(e) Багш-нисгэгч, хэрэглэлийн нислэгийн цаг уурын бодит нөхцөлд, агаарын хөлгийн нислэгийн удирдлагыг гардан гүйцэтгэж байгаа нисгэгчид хяналт тавьсан бол, тухайн цагийг хэрэглэлийн нислэгийн цагтаа оруулж тооцох эрхтэй.

(f) Шалгагч-нисгэгч нь нислэгийн шалгалт авсан тухайн цагийг хөлгийн даргын нислэгийн цагтаа оруулж тооцох эрхтэй.

(g) А, эсхүл В-Категорийн багш-нисгэгч нь коммерийн нисгэгчийн үнэмлэхний нутаг дамнасан (cross country) нислэгийн шалгалт авсан тухайн цагийг хөлгийн даргын нислэгийн цагт оруулж тооцох эрхтэй.

(h) Нисгэгч нь хэрэглэлийн, нутаг дамнасан, эсхүл шөнийн нислэгийн, эсхүл эдгээрийн аливаа хосолсон цагийг нисгэгчийн үнэмлэхний маяг, эсхүл зэрэглэл дээшлүүлэх туршлагын шаардлага хангах зорилгоор давхардуулан оруулж тооцохгүй.

(i) Нисгэгч нь, хяналтад байгаа хөлгийн даргаар (PIC/US) бүртгэгдсэн нислэгийн цагийг агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний нислэгийн цагийн туршлагын шаардлагад оруулж тооцохгүй.

(j) ИНД-135.505(b)(3)-ын зорилгоор, үйл ажиллагааны дадлага авч байгаа байгаа нисгэгчид хяналт тавихаар хөлгийн даргаар томилогдсон нисгэгч нь, хэрэв тухайн хяналтыг ИНД-135.505(c)(2)-ын дагуу ганц нисгэгчтэй агаарын хөлөг дээр гүйцэтгэсэн бол, тухайн хөлгийн даргын нислэгийн цагийг агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний нислэгийн цагийн туршлагын шаардлагад оруулж тооцохгүй.

61.33. Нисгэгчийн дэвтэр - дадлагажуурын цаг тооцох

(a) Нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл эзэмших, эсхүл зэрэглэл сунгах хүсэлт гаргагч нь, , зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчийн хяналтад, зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуурт үйлдсэн нислэгийн цагт тооцох эрхтэй, гэхдээ зөвхөн, хэрэв багш-нисгэгч тухайн цагийг нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан бол.

(b) Хэрэв энэ зүйлийн (a)-д заасан цаг нь хэрэглэлийн нислэгийн цаг бол, үүнийг дадлагажуурын хэрэглэлийн нислэгийн цагт оруулж тооцох үүрэгтэй.

61.35. Эрүүл мэндийн шаардлага

(a) Сонирхогч нисгэгчийн үнэмлэхнээс бусад нисгэгчийн үнэмлэх эзэмшигч этгээд нь дараахаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

(1) тухайн этгээд нь:

- (i) хувийн нисгэгчийн үнэмлэхтэй бол, ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх;
- (ii) коммерийн нисгэгчийн үнэмлэх болон агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй бол, ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 1-р ангиллын ЭМГ эзэмшдэг байх;
- (iii) ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх; эсхүл

(2) Хэрэв тухайн этгээдэд гадаадын нисгэгчийн үнэмлэхийг нь үндэслэн Дарга 61.153(b)-гийн дагуу хувийн нисгэгчийн үнэмлэх олгосон бол, тухайн этгээд нь:

- (i) хувийн нисгэгчийн үнэмлэх олгохдоо Даргын үндэслэл болгосон гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд дагалдах ЭМГ эзэмшдэг ба тухайн гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд дагалдах ЭМГ-ний хугацаа дуусаагүй байх;
- (ii) ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх,

(b) Сонирхогчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч этгээдэд дараахаас бусад тохиолдолд, тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

(1) В болон С ангиллын жолооны үнэмлэхэнд хамаарах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгосон дараах эрүүл мэндийн тодорхойлолттой байх:

- (i) өмнөх 5 жилийн дотор олгосон; эсхүл
- (ii) хэрэв тухайн этгээд нь 40, эсхүл түүнээс дээш настай бол, өмнөх 24 сарын дотор олгосон;

(2) эрүүл мэндийн тодорхойлолтын бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх.

(c) Гадаадын нисгэгчийн үнэмлэхний баталгаажуулах зөвшөөрөл эзэмшигч этгээдэд дараахаас бусад тохиолдолд, тухайн зөвшөөрлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн баталгаажуулах зөвшөөрөл олгосон гадаадын нисгэгчийн үнэмлэхэнд хамаарах хүчинтэй ЭМГ эзэмшдэг байх;
- (2) ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийг дагаж мөрддөг байх.

(d) Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгосон эрүүл мэндийн тодорхойлолтыг энэ зүйлийн (b), эсхүл 61.355(a)(2)-ын дагуу эзэмших шаардлагатай этгээд нь эрүүл мэндийн тодорхойлолт олгосноос хойш 7 хоногийн дотор хуулбарыг Даргад хүргүүлэх үүрэгтэй.

61.37. Нислэгийн туршлага хадгалах

(a) **Агаарын тээвэрлэгчийн нисгэгч:** тухайн нислэгийн өмнөх 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч этгээдийг, хөлгийн дарга нь агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй байхыг шаарддаг иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) тухайн этгээд нь:
 - (i) 3-аас доошгүй хөөрөлт ба 3-аас доошгүй буулт үйлдсэн байх (агаарын хөлгийн даргаар, эсхүл ижил маягийн зөвшөөрөгдсөн нислэгийн синтетик дадлагажуур дээр); эсхүл
 - (ii) зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгчид ур чадварын хадгалалтаа ижил маягийн агаарын хөлгөөр амжилттай шалгуулсан байх; эсхүл
 - (iii) зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид, хөөрөлт болон буултын маневр хийх ур чадвараа ижил маягийн агаарын хөлгөөр, өдрийн цагаар амжилттай шалгуулсан байх; гэхдээ
- (2) нэг буулт нь автопилотын автоматаар буулт үйлдэх горим ашигласан хяналттай буулт байж болно.

(b) **Коммерийн нисгэгч (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг), хувийн нисгэгч, сонирхогч нисгэгч - өдрийн нислэг:** тухайн нислэгийн өмнөх 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг өдрийн цагаар, иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг, мөн коммерийн нисгэгчийн, эсхүл хувийн нисгэгчийн, эсхүл сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээдийг өдрийн цагаар, зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг тус тус хориглоно:

- (1) өдрийн цагаар 3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буулт үйлдсэн байх (агаарын хөлгийн даргаар, эсхүл ижил маягийн зөвшөөрөгдсөн нислэгийн синтетик дадлагажуур дээр); эсхүл
- (2) зохих ёсоор мэргэшсэн А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчид хөөрөлт, буултын маневр хийх ур чадвараа ижил маягийн агаарын хөлгөөр, өдрийн цагаар амжилттай шалгуулсан байх; эсхүл

(3) энэ Дүрмийн дагуу тохирох нисгэгчийн үнэмлэх олгоход тавих ур чадвараа ижил маягийн агаарын хөлөгт амжилттай шалгуулсан байх.

(с) **Коммерийн нисгэгч, хувийн нисгэгч - шөнийн нислэг:** тухайн нислэгийн өмнөх 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг шөнийн цагаар, иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг, мөн коммерийн нисгэгчийн, эсхүл хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээдийг шөнийн цагаар, зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг тус тус хориглоно:

(1) шөнийн цагаар 3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буулт үйлдсэн байх (агаарын хөлгийн даргаар, эсхүл ижил маягийн зөвшөөрөгдсөн нислэгийн синтетик дадлагажуур дээр); эсхүл

(2) зохих ёсоор мэргэшсэн А, эсхүл В -Категорийн багш-нисгэгчид хөөрөлт болон буултын маневр хийх ур чадвараа ижил маягийн агаарын хөлгөөр, шөнийн цагаар амжилттай шалгуулсан байх.

(са) **Коммерийн нисгэгч (бөмбөлөг):** тухайн нислэгийн өмнөх 90 хоногийн дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх (бөмбөлөг) эзэмшигчийг зорчигч тээвэрлэж байгаа бөмбөлгийн хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

(1) 150м-ээс (500ft) доошгүй өндөрт гарах бүрдээ, хөлгийн даргаар 3-аас доошгүй хөөрөлт болон 3-аас доошгүй буултыг өдрийн цагаар гүйцэтгэсэн байх; эсхүл

(2) ижил маягийн бөмбөлгөөр хөөрөлтийн болон буултын маневр хийх ур чадвараа Даргын хүлээн зөвшөөрөхүйц зохих ёсоор мэргэшсэн этгээдэд амжилттай шалгуулсан байх; эсхүл

(3) энэ Дүрмийн дагуу коммерийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих ур чадвараа ижил маягийн бөмбөлөг дээр амжилттай шалгуулсан байх.

(d) Энэ зүйлийн (a)(1), (b)(1), эсхүл (c)(1)-ийн шаардлага хангахын тулд, нисдэг тэрэгний нисгэгч нь тухайн шаардлагатай хөөрөлт болон буултын хооронд шилжих хайрцагар нисэх үүрэгтэй.

(e) [Хүчингүй]

(f) Энэ зүйлийн (b)(1)-д заасан шаардлагыг хангахын тулд, глайдерын нисгэгч нь хөөргөлтийн тохирох аргаар 3 удаа гүйцэтгэсэн байх үүрэгтэй.

(g) Энэ зүйлийн (b)(1) болон (c)(1)-д шаардсан 3 хөөрөлт болон 3 буулт үйлдэх шаардлагыг хангах зорилгоор хүчинтэй А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь өдөр, эсхүл шөнийн аль алинд үйлдсэн хөөрөлт болон буултыг тооцож болно.

(h) Багш-нисгэгч нь нислэгийн зааварчилгаа өгөхийн өмнө өдрийн, эсхүл шөнийн нислэгийн туршлага хадгалах шаардлагын аль хамааралтайг нь хангасан байх үүрэгтэй.

(i) Хэрэв энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь 61.39-ийн шаардлагыг 5 жил, эсхүл түүнээс дээш хугацаанд хангаагүй бол, дараахаас бусад тохиолдолд, тухайн нисгэгчийн үнэмлэхний эрхийг дахин хэрэгжүүлэхгүй:

- (1) нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь нисэхийн хууль, дүрмийн зөвшөөрөгдсөн шалгалтыг амжилттай өгсөн ба тухайн үнэмлэхэнд холбогдох, хүчинтэй байх шаардлагыг хангасан байх (гэхдээ тухайн эзэмшигч нь өөр категорийн агаарын хөлгийн хүчинтэй нисгэгчийн үнэмлэхтэй бөгөөд 61.39(а)-д заасан тухайн категорид тавих шаардлагыг хангаж байгаа бол хамаарахгүй); эсхүл
- (2) агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний хувьд, тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь ИНД-121, 125, эсхүл 135-д шаардсан, аль хамааралтай, тохирох үйл ажиллагааны ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн байх.

61.39. Хоёр жилийн нислэгийн үнэлгээ

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, хууль болон энэ Дүрмийн дагуу Даргын олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг, дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалт өгснөөс хойш 24 сараас хэтрэхгүй хугацаанд тухайн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) өмнөх 24 сарын дотор энэ зүйлийн (c)-гийн дагуу хоёр жилийн нислэгийн үнэлгээг амжилттай өгсөн байх; эсхүл
- (2) глайдерын нисгэгчийн үнэмлэхний хувьд, өмнөх 24 сарын дотор глайдерын байгууллагаар хийгдсэн хоёр жилийн нислэгийн үнэлгээг амжилттай өгсөн байх.

(b) Хууль болон энэ Дүрмийн дагуу Даргын олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч энэ зүйлийн (а)-д заасан хоёр жилийн нислэгийн үнэлгээ хийлгэх шаардлагагүй, хэрэв үнэмлэх эзэмшигч нь:

- (1) тухайн нисгэгчийн үнэмлэхэнд хамааралтай, ИНД-115, эсхүл 119, болон 121, 125, эсхүл 135-д заасан нисэх багийн ур чадварын шалгалтын шаардлагыг хангасан бол; эсхүл
- (2) 61.707-д заасан ХАА-н зэргийн хүчинтэй байх шаардлагыг хангасан бол; эсхүл
- (3) хүчинтэй А, В, эсхүл С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшиж байгаа бол.

(c) Хоёр жилийн нислэгийн үнэлгээ нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

- (1) зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчээр хийгдсэн байх;
- (2) тухайн эзэмшигчийн хэрэгжүүлэхийг хүсэж байгаа нисгэгчийн үнэмлэхний эрхтэй хамааралтай маневр болон журмын гүйцэтгэлийг шалгах нислэгийн зааварчилгаанаас бүрдсэн байх;
- (3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу байх.

(d) Хоёр жилийн нислэгийн үнэлгээ хийж байгаа багш-нисгэгч нь дараах үүрэгтэй:

- (1) нислэгийн үнэлгээг амжилттай хийсний дараа тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдээллийг багтаасан зохих тэмдэглэлийг нэн даруй оруулах:
- (i) тухайн нислэгийн үнэлгээнд хамаарах нисгэгчийн үнэмлэхний маяг;
 - (ii) тухайн нислэгийн үнэлгээг хийсэн огноо;
 - (iii) тухайн нислэгийн үнэлгээний хүчинтэй хугацаа дуусах огноо;
 - (iv) тухайн нислэгийн үнэлгээг хийсэн багш-нисгэгчийн нэр, категори болон ИНЕГ-ын үйлчлүүлэгчийн дугаар,
- (2) ИНЕГ-ын холбогдох Хоёр жилийн нислэгийн үнэлгээний гүйцэд бөглөсөн маягтын хуулбарыг Дарга болон тухайн нисгэгчид хүргүүлэх.

(е) Энэ зүйлийн (а)-д шаардсан хоёр жилийн нислэгийн үнэлгээг, шаардсан хугацаанаас өмнө 60 хоногийн дотор амжилттай өгсөн нисгэгчийг хоёр жилийн нислэгийн үнэлгээг тухайн шаардсан хугацаанд хийлгэсэнд тооцно.

61.41. Доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл ашиглах

(а) Энэ Дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх, эсхүл коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 1-р ангиллын ЭМГ эзэмшдэггүй, гэхдээ ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллын ЭМГ эзэмшдэг бол, хувийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлж болно, хэрэв тухайн нисгэгч нь хувийн нисгэгчийн үнэмлэхний маягийн хүчинтэй байх шаардлагыг хангаж байгаа бол.

(b) Энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн нисгэгчийн үнэмлэхний маягийн хувьд, 61.207, эсхүл 61.257-гийн хүчинтэй байх шаардлагыг хангаагүй боловч доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг хангаж байгаа бол, доод эрэмбийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлж болно.

61.43. Мэргэжлийн ур чадварын шалгалт

(а) Хэрэв Дарга, энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхдээ ур чадваргүй хэлбэрээр гүйцэтгэсэн гэж үзэх бодит үндэслэл байвал, Дарга бичгээр мэдэгдэл өгч, тухайн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигчийг шалгалт, эсхүл нислэгийн шалгалт өгөхийг шаардаж болно.

(b) Энэ зүйлийн (а)-ийн дагуу Даргын шаардаж болох шалгалт, эсхүл нислэгийн шалгалт нь тухайн эзэмшигчийн хэрэгжүүлж байгаа нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэлийн хувьд, энэ Дүрмийн дагуу шаардсан шалгалт, эсхүл нислэгийн шалгалтын хэсэг, эсхүл хэсгүүдээс бүрдэнэ.

(c) Энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэх, эсхүл зэрэглэл эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (а)-ийн дагуу Даргын шаардаж болох шалгалт, эсхүл нислэгийн шалгалтыг өгөх;

- (2) шалгалт, эсхүл нислэгийн шалгалтыг өгсөн байхаар Даргын тогтоосон хугацаанд тухайн шалгалт, эсхүл нислэгийн шалгалтыг өгсөн байх.

В Бүлэг - Агаарын хөлгийн маягийн зэрэглэл

61.51. Зорилго

Энэ Бүлэг нь агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгоход тавих шаардлагыг тогтооно.

61.53. Нөхцөл хангах шаардлага

- (a) Аливаа этгээд нь агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:
- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
 - (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц шилжих сургалтын зааварчилгааны нислэгийн туршлагатай байх;
 - (3) турбин хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд, турбин хөдөлгүүрийн онолын суурь мэдлэгийн зөвшөөрөгдсөн шалгалтыг амжилттай өгсөн байх;
 - (4) тухайн зэрэглэл шаардсан агаарын хөлгийн маягийн техникийн хангалттай мэдлэгээ зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид амжилттай шалгуулсан байх;
 - (5) тухайн зэрэглэл шаардсан агаарын хөлгийн маягт хамаарах хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн маневруудыг өндөр түвшинд гүйцэтгэх ур чадвараа маягийн ур чадварын шалгалтаар зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид шалгуулсан байх;
 - (6) хэрэв, МСТOW нь 5700кг-аас дээш жинтэй агаарын хөлгийн маягийн зэрэглэл, эсхүл олон хөдөлгүүрт нисдэг тэрэгний маягийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргаж байгаа бол:
 - (i) тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл шаардсан агаарын хөлөг дээр зөвшөөрөгдсөн техникийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх;
 - (ii) тухайн агаарын хөлгийн системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журам болон тухайн агаарын хөлгийн үзүүлэлт, жин, төвлөрөлтийг багтаасан зөвшөөрөгдсөн бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх;
 - (7) хэрэв, МСТOW нь 5700кг-аас бага жинтэй, ганц хөдөлгүүрт нисдэг тэрэгний маягийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргаж байгаа бол, тухайн нисдэг тэрэгний системийн үйл ажиллагааны хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журам, нисдэг тэрэгний үзүүлэлт, жин, төвлөрөлтийг багтаасан, зөвшөөрөгдсөн бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх. Гэхдээ МСТOW нь 1500кг-аас ихгүй жинтэй нисдэг тэрэгний хувьд, зөвхөн аман шалгалт өгнө.

61.55. Зэрэглэл олгох

(a) Хэрэв тухайн нисгэгч, 61.53-ын нөхцөл хангах шаардлагыг хангасан бол, маягийн ур чадварын шалгалтыг хариуцсан багш-нисгэгч нь дараах үүрэгтэй:

- (1) тухайн нисгэгчийн дэвтэрт агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр тэмдэглэх;
- (2) тухайн маягийн зэрэглэлийн сургалтын бүртгэлийн бүрэн гүйцэд хувийг Даргад хүргүүлэх.

(b) 61.53-ыг үл харгалзан, Дарга энэ Дүрмийн дагуу олгосон нисгэгчийн үнэмлэхэнд агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг баталгаажуулан тэмдэглэж болно, хэрэв:

- (1) тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчид ИCAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгосон ба тухайн үнэмлэх эзэмшигч нь агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр эзэмшдэг болохоо нотлох баримтаар харуулсан бол; эсхүл
- (2) тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь ИНД-19.405(1)-ийн дагуу тухайн маягийн агаарын хөлгийн туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхээр зөвшөөрөгдсөн ба Даргын хүлээн зөвшөөрөхүйц агаарын хөлгөөр туршилтын нислэг хийх туршлагатай болсон бол; эсхүл
- (3) тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч ба тодорхой нисэх онгоцны конфигурацийн хувьд, 61.5(о)-д заасан агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц нисэх онгоцоор нислэгийн туршлага хуримтлуулсан бол; эсхүл
- (4) тухайн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь 61.57-гийн дагуу тухайн маягийн агаарын хөлөгт нисгэгч, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхээр зөвшөөрөгдсөн бөгөөд Даргын хүлээн зөвшөөрөхүйц агаарын хөлөг дээр нислэгийн туршлагатай болсон бол.

(c) Нисгэгч нь Даргад хүсэлт гарган, зохих төлбөрийн баримт хүргүүлж, агаарын хөлгийн маягийн зэрэглэлийг (нисгэгчийн дэвтэрт тэмдэглэхээс гадна) нисгэгчийн үнэмлэхэндээ баталгаажуулсан тэмдэглэл хийлгэж болно.

(d) Энэ Дүрмийн 61.55(a)-ийг үл харгалзан, зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч нь тухайн нисгэгчийн эзэмшиж байгаа агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй маш төстэй агаарын хөлгийн маягийн хувьд, хэрэв тухайн багш нь нэмэлт шилжих нислэгийн зааварчилгаа, эсхүл тухайн маягийн ур чадварын шалгалт шаардлагагүй гэж үзвэл, агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгож болох ба:

- (1) тухайн нисгэгчийн дэвтэрт тохирох тэмдэглэлийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр оруулах;
- (2) тухайн багш нисгэгч нь нисгэгчийн дэвтрийн холбогдох тэмдэглэлийн баталгаажуулсан хувийг Даргад хүргүүлнэ.

61.57. Анхдагч маягийн эрх

Дарга, энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч багш-нисгэгчид, маягийн зэрэглэл эзэмшдэггүй агаарын хөлөгт нисгэгчийн, эсхүл агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх эрх олгож болно. Дарга эрх олгохдоо, нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзсэн нөхцөлийг зааж өгч болно.

С Бүлэг - Сурагч-нисгэгч**61.101. Зорилго**

Энэ Бүлэг нь, энэ Дүрмийн дагуу олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй байх үедээ, агаарын хөлгийн нисгэгчийн (микралайт агаарын хөлөг, ханг-глайдер, глайдер, мото-глайдер, эсхүл бөмбөлгөөс бусад) үүрэг гүйцэтгэх этгээдэд тавих шаардлага болон хязгаарлалтыг тогтооно.

61.103. Ерөнхий зүйл

(а) Энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй этгээдийг дараахаас бусад тохиолдолд, агаарын хөлгийн удирдлагыг гардан гүйцэтгэхийг хориглоно, хэрэв тухайн этгээд нь:

- (1) нисгэгчийн суудалд сууж байгаа, зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчээс хосолсон нислэгийн зааварчилгаа авч байгаа бол; эсхүл
- (2) 61.105-ын дагуу хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж байгаа бол.

(b) Энэ зүйлийн (а)(1)-ийн дагуу хосолсон нислэгийн зааварчилгаа авч байгаа этгээд нь тухайн цагийг хамтарсан нислэгийн цагаар бүртгэж болно.

61.105. Бие даасан нислэгийн шаардлага

(а) Энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл хүлээн зөвшөөрсөн хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй этгээдийг дараахаас бусад тохиолдолд, агаарын хөлгөөр бие даан нисэхийг хориглоно:

- (1) тухайн этгээд нь 16 нас хүрсэн байх;
- (2) тухайн этгээд нь:
 - (i) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх; эсхүл
 - (ii) В болон С ангиллын жолооны үнэмлэхэнд хамаарах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгосон дараах эрүүл мэндийн тодорхойлолттой байх:
 - (А) өмнөх 5 жилийн дотор олгосон; эсхүл
 - (В) хэрэв тухайн этгээд 40, эсхүл түүнээс дээш настай бол, өмнөх 24 сарын дотор олгосон;

- (3) тухайн этгээд нь ЭМГ-ний бүх нөхцөл, хязгаарлалт болон баталгаажуулсан тэмдэглэлийн шаардлагыг хангасан байх;
- (4) тухайн этгээд нь агаарын хөлгийн даргын үүрэг, хариуцлагыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай хэлээр унших, ярих, ойлгох болон холбоо барих хангалттай чадвартай байх;
- (5) өдөр, эсхүл шөнийн цагаар үйлдэх анхны бие даасан нислэгийг А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч зөвшөөрснөөс бусад тохиолдолд, тухайн нислэгийг хүчинтэй А, В, эсхүл С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч зөвшөөрсөн байх;
- (6) энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, хүчинтэй А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч тухайн этгээдийн нисгэгчийн дэвтэрт зааварчилгаа авсан ба дараах ур чадвараа шалгуулсан тухай бичиж баталгаажуулсан байх:
 - (i) нислэгийн бэлтгэл;
 - (ii) хөдөлгүүр асаах болон горим шалгах ажиллагаа;
 - (iii) явгалах;
 - (iv) чиг шулуун нисэх;
 - (v) өндөр авах болон өндөр алдах;
 - (vi) түвшин хадгалах, эргэлтийн үед өндөр авах болон өндөр алдах;
 - (vii) тухайн маягийн агаарын хөлгөөр хөөрөлт, хайрцгаар нисэх болон буулт үйлдэх;
 - (viii) нислэгийн радио холбоо ашиглах;
 - (ix) хоёрдугаар хайрцагт гарах журам;
 - (x) нисэх онгоцны хувьд, тухайн маягийн нисэх онгоцоор хурдны уналтыг таньж мэдрэх (stall) болон түүнээс гарах;
 - (xi) нисэх онгоцны хувьд, хөөрөлтийн үед болон хөөрсний дараа хөдөлгүүр татгалзсан үеийн онцгой нөхцөлийн журам;
 - (xii) нисдэг тэрэгний хувьд, угтах салхи, арын салхи болон хажуугийн салхинд дүүжин нислэг (hovering) хийх;
 - (xiii) нисдэг тэрэгний хувьд, тухайн маягийн нисдэг тэрэгний (авторотацаар үйлдэх ойртолт ба буултыг багтаасан) онцгой нөхцөлийн журам.
- (7) хүчинтэй А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, тухайн этгээд нислэгийн туршлагын сүүлийн 5 цагт нь хосолсон нислэгийн зааварчилгаа авсан байх;
- (8) тухайн этгээд нь өмнөх 30 хоногийн дотор тохирох агаарын хөлгөөр ниссэн нислэгийн туршлагатай байх;
- (9) хэрэв тухайн нислэг нь нутаг дамнасан (х-country) бие даасан нислэг бол:

- (i) тухайн нислэгийг хүчинтэй А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч зөвшөөрсөн байх;
- (ii) тухайн этгээд нь хувийн нисгэгчийн үнэмлэх авахад шаардагдах бичгийн шалгалтын хүчинтэй кредитийг цуглуулсан байх.

(b) Энэ зүйлийн (a)(5)-д заасан тухайн бие даасан нислэгийг зөвшөөрсөн багш-нисгэгч нь бие даасан нислэгийн турш тухайн нисгэгчийн үйлдлийг хянах үүрэгтэй.

(c) Өдрийн цагаар үйлдэх анхны бие даасан нислэгийн хувьд, анхны бие даасан нислэг дууссаны дараа хэрэв багш-нисгэгч нь энэ зүйлийн (a)(6)(i)-ээс (xiii)-ын шаардлагыг хангасан гэж үзвэл, тухайн этгээдийн энэ зүйлийн (a)(6)-д шаардсан нисгэгчийн дэвтэрт гэрчилгээжүүлэлт хийж болно.

61.107. Хязгаарлалт

(a) Энэ Дүрмийн дагуу олгосон, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй этгээдийг дараах нислэгт агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) цалинтай (цалинтай ажилтнаар); эсхүл
- (2) хэрэв тухайн агаарын хөлгөөр хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол; эсхүл
- (3) олон улсын нислэгт; эсхүл
- (4) хэрэв тухайн агаарын хөлөгт багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчээс бусад этгээдийг тээвэрлэж байгаа бол.

(b) Энэ зүйлийн (a)-ийн шаардлага дээр нэмж, 61.105(a)(2)(ii)-ын дагуу ЭМГ эзэмшиж байгаа этгээдийг дараах үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) шөнийн цагаар; эсхүл
- (2) хяналттай аэродром руу, эсхүл хяналттай аэродромоос, тухайн үнэмлэх эзэмшигч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц өнгө ялгах харааны тестийг амжилттай өгснийг нотлох баримтыг Даргад хүргүүлснээс бусад тохиолдолд; эсхүл
- (3) буулт болон хөөрөлт үйлдэхээс бусад тохиолдолд, хот, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр.

D Бүлэг - Хувийн нисгэгчийн үнэмлэх

61.151. Зорилго

Энэ Бүлэг нь, хувийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага, үнэмлэхний эрх, хязгаарлалт болон тухайн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг тогтооно.

61.153. Нөхцөл хангах шаардлага

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) 17 нас хүрсэн байх;
- (2) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг байх;
- (3) туршлагын хувьд:
 - (i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц бие даасан нислэгийн, хамтарсан нислэгийн, хэрэглэлийн нислэгийн болон нутаг дамнасан нислэгийн (cross country) цагийг багтаасан, тохирох категорийн агаарын хөлгийн нисгэгчийн минимум 50 цагийн нислэгийн туршлагатай байх; эсхүл
 - (ii) хэрэв тухайн этгээд нь хувийн нисгэгчийн эрхийг нутаг дамнасан нислэгт (cross country) хэрэгжүүлэхийг зориогүй бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц бие даасан нислэгийн, хэрэглэлийн нислэгийн болон хамтарсан нислэгийн цагийг багтаасан, тохирох категорийн агаарын хөлгийн нисгэгчийн минимум 40 цагийн нислэгийн туршлагатай байх,
- (4) хэрэв тухайн этгээд нь хувийн нисгэгчийн эрхийг шөнийн цагаар хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн дадлага туршлагатай байх;
- (5) хэрэв тухайн этгээд нь нисдэг тэрэгний хувийн нисгэгчийн эрхийг дүүжинт тээвэрт хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүүжинт тээвэр хийх нислэгийн сургалтад хамрагдсан байх;
- (6) хувийн нисгэгчийн үнэмлэхэнд хамаарах дараах сэдвээр бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) нисэхийн хууль, дүрэм;
 - (ii) агаарын навигаци болон нислэгийн төлөвлөлт;
 - (iii) цаг уур;
 - (iv) агаарын хөлгийн техникийн мэдлэг (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг), аль хамааралтайг;
 - (v) хүний хүчин зүйл;
 - (vi) нислэгийн радио холбоо;

(7) дараах мэдлэг болон ур чадвараа шалгагч-нисгэгчид нислэгийн шалгалтаар амжилттай харуулсан байх:

- (i) “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-д тусгасан дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, энэ зүйлийн (а)(6)-д заасан газрын-бэлтгэл шалгалтын сэдвийн мэдлэг;
- (ii) хувийн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын мэдлэг;
- (iii) тухайн нислэгийн шалгалтад ашиглах агаарын хөлгийн маягтай холбоотой техникийн болон үйл ажиллагааны мэдлэг;
- (iv) бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журмын үед хангалттай түвшинд нөхцөл байдлыг зөв тодорхойлж, шийдвэр гарган удирдах дадлага хийж байхдаа тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу, түүний үзүүлэлтийн чадал, хязгаарлалтын хүрээнд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх ур чадвар;
- (v) радио холбоо болон фразеолог /стандарт хэллэгийн ур чадвар;
- (vi) нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлд хэзээ ч эргэлзээ төрөхгүй байх хэлбэрээр нислэгийн туршид тухайн агаарын хөлгийг итгэлтэй удирдах.

(b) Хуулийн дагуу, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх болон холбогдох ЭМГ эзэмшдэг этгээд нь, ижил категорийн агаарын хөлгийн хувьд, Дарга тухайн этгээдэд хувийн нисгэгчийн үнэмлэх олгох зорилгод нийцсэн үнэмлэх болон ЭМГ-тэй байж болно.

(c) Даргын шилжүүлсэн эрхийн хүрээнд, глайдерын байгууллагаас олгосон хүчинтэй глайдерын нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг этгээд нь хувийн нисгэгчийн үнэмлэх (глайдер) эзэмших эрхтэй, хэрэв тухайн этгээд нь:

- (1) 17 нас хүрсэн бол;
- (2) нислэгийн радио холбооны шалгалтын кредиттэй бол;
- (3) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 2-р ангиллаас доошгүй ЭМГ эзэмшдэг бол.

(d) Нислэгийн туршлагаа хадгалан, Монгол Улсын зэвсэгт хүчний хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж байгаа этгээдийг Дарга дараах шаардлагыг хангасанд тооцож болно:

- (1) энэ зүйлийн (а)(6), хэрэв тухайн этгээд, хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 5 жилд холбогдох нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг амжилттай өгсөн бол;
- (2) энэ зүйлийн (а)(7).

61.155. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)(3)-ыг харгалзан, хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь:

- (1) тухайн нисгэгчийн үнэмлэхэнд олгосон агаарын хөлгийн категориор агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг агаарын хөлөгт хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх ба тухайн агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэх;
- (2) тухайн нисгэгчийн үнэмлэхэнд олгосон агаарын хөлгийн категориор агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг, хамтран нисгэгчтэй үйл ажиллагаа гүйцэтгэхийг шаарддаг агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.

(b) Дараах тохиолдолд, хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) цалинтай (цалинтай ажилтнаар); эсхүл
- (2) хэрэв тухайн агаарын хөлгөөр хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол; эсхүл
- (3) зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч, нисгэгчийн дэвтэрт нь тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай нислэгийн сургалтад амжилттай хамрагдсаныг тэмдэглэснээс бусад тохиолдолд, тухайн агаарын хөлгөөр:
 - (i) шөнийн цагаар, үйл ажиллагаа гүйцэтгэхийг; эсхүл
 - (ii) нутаг дамнасан нислэгийн (cross country) үйл ажиллагаа гүйцэтгэхийг; эсхүл
 - (iii) нисдэг тэрэгний дүүжинт тээвэр хийхийг.

(c) Энэ зүйлийн (b)(2)-ыг үл харгалзан, хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь глайдерыг нислэгт чирэх хөлс, эсхүл шан урамшуулалтай гэхдээ цалингүй үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөгт хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно, гэхдээ зөвхөн, хэрэв тухайн үйл ажиллагаа нь глайдерын байгууллагын шууд хяналтад, эсхүл ИНД-115-ын дагуу Даргын олгосон чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд хийгдэж байгаа бол.

61.157. Хүчинтэй байх шаардлага

Хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн эзэмшиж байгаа хувийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.35 (Эрүүл мэндийн шаардлага), 61.37 (Нислэгийн туршлага хадгалах) болон 61.39-д (Хоёр жилийн нислэгийн үнэлгээ) заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

Е Бүлэг - Коммерийн нисгэгчийн үнэмлэх

61.201. Зорилго

Энэ Бүлэг нь, коммерийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага, үнэмлэхний эрх, хязгаарлалт болон тухайн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг тогтооно.

61.203. Нөхцөл хангах шаардлага

(а) Аливаа этгээд нь коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) 18 нас хүрсэн байх;
- (2) нисэх онгоц болон нисдэг тэрэгний хувьд, тохирох категорийн агаарын хөлгийн хүчинтэй хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (3) ИНД-67-гийн дагуу олгосон хүчинтэй 1-р ангиллын ЭМГ эзэмшдэг байх;
- (4) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц тодорхой нислэгийн туршлагаас бүрдсэн нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн дараах минимум ерөнхий нислэгийн цагийн туршлагатай байх:
 - (i) нисэх онгоцны хувьд, 200 цагийн, эсхүл хэрэв зөвшөөрөгдсөн сургалтын курсийг төгссөн бол, 150 цагийн;
 - (ii) нисдэг тэрэгний хувьд, 150 цагийн, эсхүл хэрэв зөвшөөрөгдсөн сургалтын курсийг төгссөн бол, 125 цагийн;
 - (iii) глайдерын хувьд, 150 цагийн;
 - (iv) бөмбөлгийн хувьд, 50 цагийн;
- (5) хэрэв тухайн этгээд нь коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг шөнийн цагаар хэрэгжүүлэхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн цагийн туршлагатай байх;
- (6) коммерийн нисгэгчийн үнэмлэхэнд хамаарах дараах сэдвээр бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) нисэхийн хууль, дүрэм;
 - (ii) нислэгийн навигацийн ерөнхий мэдлэг;
 - (iii) цаг уур;
 - (iv) нислэгийн зарчим болон агаарын хөлгийн үзүүлэлт (нисэх онгоц, нисдэг тэрэг, эсхүл глайдерын аль хамааралтайг);
 - (v) агаарын хөлгийн техникийн ерөнхий мэдлэг (нисэх онгоц, нисдэг тэрэг, эсхүл глайдерын аль хамааралтайг);
 - (vi) бөмбөлгийн техникийн мэдлэг болон аэростатик (бөмбөлөг);
 - (vii) хүний хүчин зүйл;

- (7) нислэгийн шалгалтаар дараах мэдлэг, ур чадвараа Даргад амжилттай харуулсан байх:
- (i) “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-д дэлгэрэнгүй тусгасан мэдээллийг багтаасан, энэ зүйлийн (а)(6)-д заасан газрын бэлтгэлийн шалгалтын сэдвийн мэдлэг;
 - (ii) коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын мэдлэг;
 - (iii) тухайн нислэгийн шалгалтад ашиглах агаарын хөлгийн маягт хамаарах техникийн болон үйл ажиллагааны мэдлэг;
 - (iv) бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журмын үед хангалттай түвшинд нөхцөл байдлыг зөв тодорхойлж, шийдвэр гарган удирдах дадлага хийж байхдаа тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу, түүний үзүүлэлтийн чадал, хязгаарлалтын хүрээнд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх ур чадвар;
 - (v) радио холбоо болон фразеолог /стандарт хэллэгийн ур чадвар;
 - (vi) нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлд хэзээ ч эргэлзээ төрөхгүй байх хэлбэрээр нислэгийн туршид тухайн агаарын хөлгийг итгэлтэй удирдах.

(b) Нислэгийн туршлагаа хадгалан, Монгол Улсын зэвсэгт хүчний хөлгийн дарга, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж, мэргэшлээ хадгалж байгаа этгээдийг Дарга дараах шаардлагыг хангасанд тооцож болно:

- (1) энэ зүйлийн (а)(2);
- (2) энэ зүйлийн (а)(6), хэрэв тухайн этгээд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 5 жилд холбогдох нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг амжилттай өгсөн бол;
- (3) энэ зүйлийн (а)(7).

61.205. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх нь, тухайн үнэмлэх болон агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг ижил категорийн агаарын хөлөг дээр дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:

- (1) хувийн нисгэгчийн үнэмлэхний холбогдох аливаа эрх;
- (2) хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд оролцож байгаа ганц нисгэгчтэй гэрчилгээжсэн агаарын хөлгийн үйл ажиллагаанд хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;
- (3) агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд оролцож байгаа олон нисгэгчтэй гэрчилгээжсэн агаарын хөлгийн үйл ажиллагаанд хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх;
- (4) хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд оролцож байгаа олон нисгэгчтэй гэрчилгээжсэн агаарын хөлгийн үйл ажиллагаанд хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх.

(b) Эзэмшигч нь тухайн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай шөнийн нислэгийн сургалтыг амжилттай төгссөн талаар зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгч, тухайн нисгэгчийн дэвтэрт нь тэмдэглэл хийснээс бусад тохиолдолд, коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг шөнийн цагаар агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

61.207. Хүчинтэй байх шаардлага

Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн эзэмшиж байгаа коммерийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.35 (Эрүүл мэндийн шаардлага), 61.37 (Нислэгийн туршлага хадгалах) болон 61.39-д (Хоёр жилийн нислэгийн үнэлгээ) заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

F Бүлэг - Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх

61.251. Зорилго

Энэ Бүлэг нь агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага, үнэмлэхний эрх болон тухайн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг тогтооно.

61.253. Нөхцөл хангах шаардлага

(a) Аливаа этгээд нь агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) 21 нас хүрсэн байх;
- (2) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (3) хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (4) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, Даргын хүлээн зөвшөөрөхүйц тодорхой нислэгийн туршлагаас бүрдсэн нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн дараах минимум ерөнхий нислэгийн цагийн туршлагатай байх:
 - (i) нисэх онгоцны хувьд, 1500 цагийн;
 - (ii) нисдэг тэрэгний хувьд, 1000 цагийн;
- (5) агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхэнд хамаарах дараах сэдвээр бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) нисэхийн хууль, дүрэм;
 - (ii) нислэгийн навигацийн ерөнхий мэдлэг;
 - (iii) нислэгийн төлөвлөгөө (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний аль хамааралтайг)
 - (iv) цаг уур;

- (v) хэрэглэл болон навигацийн туслах төхөөрөмж (зөвхөн нисэх онгоц)
 - (vi) хүний хүчин зүйл;
 - (vii) гүнзгийрүүлсэн аэродинамик, техникийн үзүүлэлт болон системийн талаарх мэдлэг (зөвхөн нисэх онгоц);
 - (viii) аэродинамик болон агаарын хөлгийн систем (зөвхөн нисдэг тэрэг);
 - (ix) техникийн үзүүлэлт болон ачаалалт (зөвхөн нисдэг тэрэг);
- (6) энэ зүйлийн (b)-г харгалзан, дараах мэдлэг, ур чадвараа нислэгийн шалгалтаар Даргад, эсхүл ИНД-119-ийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний, эсхүл ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа, зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгчид амжилттай харуулсан байх, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол:
- (i) “хангалтгүй дүгнэгдсэн мэдлэгийн тайлан”-д тусгасан дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан, энэ зүйлийн (a)(5)-д заасан газрын бэлтгэлийн шалгалтын сэдвийн мэдлэг;
 - (ii) агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын мэдлэг;
 - (iii) тухайн нислэгийн шалгалтад ашиглах агаарын хөлгийн маягтай холбоотой техникийн болон үйл ажиллагааны мэдлэг;
 - (iv) бүх хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийн журмын үед хангалттай түвшинд нөхцөл байдлыг зөв тодорхойлж, шийдвэр гарган удирдах дадлага хийж байхдаа тухайн агаарын хөлгийн нислэгийн зааврын дагуу, түүний үзүүлэлтийн чадал, хязгаарлалтын хүрээнд тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх ур чадвар;
 - (v) НХҮ-ний журам болон фразеолог/стандарт хэллэгийн ур чадвар;
 - (vi) нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлд хэзээ ч эргэлзээ төрөхгүй байх хэлбэрээр нислэгийн туршид тухайн агаарын хөлгийг итгэлтэй удирдах;
- (b) Энэ зүйлийн (a)(6)-д шаардсан нислэгийн шалгалт нь ХНД-ийн дагуу үйлдэгдэх нутаг дамнасан нислэг (cross country) байх ёстой ба агаарын хөлөг нь:
- (1) МСТOW нь 5700кг, эсхүл түүнээс дээш, олон хөдөлгүүрт агаарын хөлөг; эсхүл
 - (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц олон хөдөлгүүрт агаарын хөлөг; эсхүл
 - (3) агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалтад зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуур байна.

(с) Дарга, өмнөх 12 сарын дотор тохирох категорийн 2 нисгэгчтэй агаарын хөлгийн даргаар, өдөр/шөнийн цагаар нислэгийн цаг хуримтлуулан ниссэн туршлагатай Монгол Улсын зэвсэгт хүчний алба хаагч этгээдийг дараах шаардлагыг хангасанд тооцож болно:

- (1) энэ зүйлийн (а)(2);
- (2) энэ зүйлийн (а)(3), хэрэв тухайн этгээд, агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 3 сард Монгол Улсын зэвсэгт хүчний хэрэглэлийн нислэгийн үнэлгээг амжилттай хийлгэсэн бол;
- (3) энэ зүйлийн (а)(5), хэрэв тухайн этгээд, агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргахын өмнөх 5 жилд холбогдох нисэхийн хууль, дүрмийн шалгалтыг амжилттай өгсөн бол;
- (4) энэ зүйлийн (а)(6).

61.255. Эрх

Хүчинтэй агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх нь эзэмшигчид, тухайн олгосон нисгэгчийн үнэмлэх болон агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг ижил категорийн агаарын хөлөгт дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:

- (1) хувийн болон коммерийн нисгэгчийн үнэмлэхний аливаа эрх;
- (2) агаарын тээврийн үйл ажиллагаа, эсхүл хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд оролцож байгаа, хамтран нисгэгчтэй үйл ажиллагаа гүйцэтгэхийг шаарддаг агаарын хөлөгт хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх.

61.257. Хүчинтэй байх шаардлага

Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн эзэмшиж байгаа агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.35 (Эрүүл мэндийн шаардлага), 61.37 (Нислэгийн туршлага хадгалах) болон 61.39-д (Хоёр жилийн нислэгийн үнэлгээ) заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

G Бүлэг - Багш-нисгэгчийн зэрэглэл

61.301. Зорилго

Энэ Бүлэг нь багш-нисгэгчийн зэрэглэл олгоход тавих шаардлага болон тухайн зэрэглэлийн эрх, хязгаарлалт болон хүчинтэй байх шаардлагыг тогтооно.

61.303. Нөхцөл хангах шаардлага

Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл

(а) Аливаа этгээд нь Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, агаараас бордоо, шингэн, эсхүл мэрэгчийн хор цацах үйл ажиллагааны аль хамааралтайд нь хүчинтэй ХАА-н зэрэглэлийн Зэрэг-1 эзэмшдэг байх;
- (3) дараах үйл ажиллагааг багтаасан, ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааны минимум 2000 цагийн нислэгийн туршлагатай байх:
 - (i) хэрэв тухайн этгээд нь агаараас бордоо цацах үйл ажиллагаанд зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, тухайн тохирох категорийн агаарын хөлгөөр бордоо цацах үйл ажиллагаанд минимум 100 цаг нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийн туршлагатай байх;
 - (ii) хэрэв тухайн этгээд нь агаараас шингэн цацах үйл ажиллагаанд зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, тухайн тохирох категорийн агаарын хөлгөөр шингэн цацах үйл ажиллагаанд минимум 100 цаг нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийн туршлагатай байх;
 - (iii) хэрэв тухайн этгээд нь агаараас хортон мэрэгчийн хор цацах үйл ажиллагаанд зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, тухайн тохирох категорийн агаарын хөлгөөр бордоо цацах үйл ажиллагааны нислэгийн цагийн туршлагыг багтаасан минимум 100 нислэгийн цагийн туршлагатай байх ба хортон мэрэгчийн хор цацах үйл ажиллагааны 50-иас доошгүй нислэгийн цагийн туршлагатай байх;
- (4) [хүчингүй]
- (5) [хүчингүй]
- (6) ХАА-н нисэхийн үйл ажиллагааны талаарх техникийн цогц мэдлэгээ Даргын хүлээн зөвшөөрөхүйц аман шалгалт болон нислэгийн шалгалтаар амжилттай өгсөн байх;
- (7) хэрэв хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч биш бол, E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахын өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц хугацаанд зөвшөөрөгдсөн зааварчилгаа өгөх арга зүйн курсэд хамрагдаж, амжилттай шалгуулсан байх.

D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл

(b) Аливаа этгээд нь D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц хөлгийн даргын туршлагыг багтаасан, минимум 700 цаг нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийн туршлагатай байх;
- (3) хэрэв тухайн этгээд нь шөнийн цагаар нислэгийн зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн туршлагатай байх;

- (4) хэрэв тухайн этгээд нь олон хөдөлгүүрт агаарын хөлөгт зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц олон хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн туршлагатай байх;
- (5) хэрэв тухайн этгээд нь хэрэглэлийн нислэгт зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, тохирох, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй байх;
- (6) Даргын хүлээн зөвшөөрөхүйц аман шалгалт болон нислэгийн шалгалтыг амжилттай өгч, агаарын хөлгийн маягийн шилжих сургалтын зааварчилгаа өгөх ур чадвараа Даргад харуулсан байх;
- (7) хэрэв багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч биш бол, нислэгийн зааварчилгаа өгөх онол болон дадлагын зөвшөөрөгдсөн сургалтын курсийг амжилттай төгссөн байх.

С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл

(с) Аливаа этгээд нь С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц тусгай нислэгийн туршлагыг багтаасан, тухайн тохирох категорийн агаарын хөлгөөр минимум 200 цаг нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийн туршлагатай байх;
- (3) хэрэв тухайн этгээд нь шөнийн цагаар нислэгийн зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн дадлага туршлагатай байх;
- (4) хэрэв тухайн этгээд нь олон хөдөлгүүрт агаарын хөлөгт зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц олон хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн туршлагатай байх;
- (5) хэрэв тухайн этгээд нь нисэх онгоцоор штопор (spinning), эсхүл аэробатик маневрын зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц аэробатик нислэгийн туршлагатай байх;
- (6) нислэгийн зааварчилгааны онол болон дадлагын зөвшөөрөгдсөн сургалтын курсийг амжилттай төгссөн байх;
- (7) дараах сэдвээр аман шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний нислэгийн зарчим болон үзүүлэлтийн аль хамааралтайг нь;
 - (ii) цаг уур;
 - (iii) нутаг дамнасан нислэгийн навигацийн аргачлал;
 - (iv) нислэгийн зааварчилгааны онол болон дадлага;
- (8) минимум 25 цагийн хосолсон нислэгийн багшийн сургалт, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх сургалтад хамрагдсан байх;

- (9) Даргын хүлээн зөвшөөрөхүйц аман шалгалт болон нислэгийн шалгалтыг амжилттай өгч, тухайн тохирох категорийн агаарын хөлөгт нислэгийн зааварчилгаа өгөх чадвараа бүх хэвийн болон онцгой нөхцөлийн нислэгийн маневрыг гүйцэтгэн Даргад харуулсан байх.

(ca) Монгол Улсын зэвсэгт хүчний хүчинтэй багш-нисгэгчийн мэргэшил эзэмшдэг этгээдийг Дарга дараах шаардлагыг хангасанд тооцож болно:

- (1) энэ зүйлийн (c)(2);
- (2) энэ зүйлийн (c)(5), хэрэв тухайн этгээд нь Монгол Улсын зэвсэгт хүчний нисэх онгоцны багшаар мэргэшсэн бол;
- (3) энэ зүйлийн (c)(8).

В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл

(d) Аливаа этгээд нь В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх зэрэглэл эзэмшигч байх;
- (3) Даргын хүлээн зөвшөөрөхүйц тусгай нислэгийн туршлагыг багтаасан, тухайн тохирох категорийн агаарын хөлгөөр минимум 500 цаг нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийн туршлагатай байх;
- (4) хэрэв тухайн этгээд нь шөнийн цагаар нислэгийн зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц шөнийн нислэгийн туршлагатай байх;
- (5) хэрэв тухайн этгээд нь олон хөдөлгүүрт агаарын хөлгөөр зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц олон хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн туршлагатай байх;
- (6) хэрэв тухайн этгээд нь нисэх онгоцоор штопор (spinning), эсхүл аэробатик маневрын зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц аэробатикийн нислэгийн туршлагатай байх;
- (7) дараах сэдвээр аман шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) хамааралтай бол нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний нислэгийн зарчим болон үзүүлэлт;
 - (ii) цаг уур;
 - (iii) нутаг дамнасан нислэгийн навигацийн аргачлал;
 - (iv) нислэгийн зааварчилгааны онол болон дадлага;
- (8) Даргын хүлээн зөвшөөрөхүйц аман шалгалт болон нислэгийн шалгалтыг амжилттай өгч, тухайн тохирох категорийн агаарын хөлөгт нислэгийн зааварчилгаа өгөх чадвараа бүх хэвийн болон онцгой нөхцөлийн нислэгийн маневрыг гүйцэтгэн Даргад харуулсан байх.

(da) Монгол Улсын зэвсэгт хүчний хүчинтэй багш-нисгэгчийн мэргэшил эзэмшдэг этгээдийг Дарга В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл олгоход тавих, энэ зүйлийн (d)(3)-т шаардсан нислэгийн цагийн туршлагыг хангасанд тооцож болно.

А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл

(e) Аливаа этгээд нь А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, В-Категорийн багш-нисгэгчийн, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх зэрэглэл эзэмшигч байх;
- (3) нисэх онгоцны хувьд, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч байх;
- (4) Даргын хүлээн зөвшөөрөхүйц тусгай нислэгийн туршлагыг багтаасан, тухайн тохирох категорийн агаарын хөлгийн минимум 1250 цагийн туршлагатай байх;
- (5) хэрэв тухайн этгээд нь олон хөдөлгүүрт агаарын хөлгийн үйл ажиллагаанд зааварчилгаа өгөхийг зорьж байгаа бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц олон хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн туршлагатай байх;
- (6) дараах сэдвээр аман шалгалтыг амжилттай өгсөн байх:
 - (i) нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний нислэгийн зарчим болон үзүүлэлтийн аль хамааралтайг нь;
 - (ii) цаг уур;
 - (iii) нутаг дамнасан нислэгийн навигацийн аргачлал;
 - (iv) нислэгийн зааварчилгаа өгөх онол болон дадлага;
- (7) нислэгийн зааварчилгааг дунджаас дээш түвшинд өгөх чадвараа тухайн тохирох категорийн агаарын хөлгөөр бүх хэвийн болон онцгой нөхцөлийн нислэгийн маневрыг (нисэх онгоцны хувьд, штопор (spinning) болон аэробатик маневрыг багтаасан) шөнийн болон өдрийн цагаар гүйцэтгэж Даргын хүлээн зөвшөөрөхүйц аман болон нислэгийн шалгалтыг амжилттай өгч Даргад харуулсан байх.

61.304. Зэрэглэл олгох

Хэрэв Дарга, багш-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагчийг 61.303-ын холбогдох шаардлагыг хангасан гэж үзвэл, энэ Дүрмийн дагуу тухайн хүсэлт гаргагчийн нисгэгчийн үнэмлэхэнд тэмдэглэл хийж, тохирох Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл олгож болно.

61.305. Эрх, хязгаарлалт**Е-Категорийн багш-нисгэгч**

(a) Тохирох, хүчинтэй Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид дараах эрхийг олгоно:

- (1) агаараас бордоо, шингэн, эсхүл мэрэгчийн хор цацах зорилгоор хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшигчид ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд техникийн болон нислэгийн зааварчилгаа өгөх;
- (2) ХАА-н зэрэглэл эзэмшээгүй, хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшигчид бордоо, шингэн, эсхүл мэрэгчийн хор цацах үйл ажиллагааны нислэгийн бие даасан дадлага хийх зөвшөөрөл олгох;
- (3) хэрэв тухайн багш-нисгэгч нь зааварчилгаанд ашиглах ижил маягийн агаарын хөлгийн даргын 50-иас доошгүй цагийн нислэгийн туршлагатай бол, 61.55-ын дагуу шилжих сургалтын зааварчилгаа өгч, ХАА-н агаарын хөлгийн маягийн зэрэглэл олгох;
- (4) [хүчингүй]
- (5) 61.707-гийн дагуу ХАА-н зэрэглэлийн ур чадварын шалгалт авах;
- (6) ОА Бүлэг (агаараас бордоо цацах), ОВ Бүлэг (агаараас шингэн цацах) болон ОС Бүлгийн (агаараас мэрэгчийн хор цацах) дагуу ур чадварын шалгалт авах.

(b) Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг дараах зүйлд заасан эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) энэ зүйлийн (a), багш-нисгэгч нь тохирох нисгэгчийн үнэмлэх болон агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг, эсхүл 61.57-гийн дагуу ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн зөвшөөрөлтэйгээс бусад тохиолдолд;
- (2) энэ зүйлийн (a)(1), багш-нисгэгч нь үйл ажиллагаанд оролцож байгаа ХАА-н агаарын хөлгийн хувьд, тохирох, хүчинтэй зэрэглэл эзэмшдэгээс бусад тохиолдолд.

(c) [Хүчингүй]

Д-Категорийн багш-нисгэгч

(d) Энэ зүйлийн (e), (f) болон (g)-г харгалзан, тохирох, хүчинтэй D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид дараах эрхийг олгоно:

- (1) нисгэгчийн үнэмлэх эзэмшигчид хэрэглэлийн зэрэглэлийн стандартаар шаардсан навигацийн туслах радио төхөөрөмж ашиглан хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөх;
- (2) агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн сургалт хийх.

(e) Энэ зүйлийн (d) нь зөвхөн, тухайн зааварчилгаанд ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд, 61.57-гийн дагуу зөвшөөрөл, эсхүл агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг D-Категорийн багш-нисгэгчид хамаарна.

(f) Тухайн багш нь дараах хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч байхаас бусад тохиолдолд, D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн;
- (2) зааварчилгаанд ашиглаж байгаа ойртолтын туслах төхөөрөмж, эсхүл системийн.

(g) Зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгч, тухайн эзэмшигч нь шаардлагатай туршлагатай бөгөөд тухайн ажиллагааны ур чадвараа шалгуулсныг эзэмшигчийн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг дараах зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) шөнийн цагаар; эсхүл
- (2) олон хөдөлгүүрт агаарын хөлөгт; эсхүл
- (3) хэрэглэлийн нислэгт.

С-Категорийн багш-нисгэгч

(h) Энэ зүйлийн (i), (j), (k) болон (l)-ийг харгалзан, тохирох, хүчинтэй С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид, тохирох, хүчинтэй В, эсхүл А-Категорийн багш-нисгэгчийн хяналтад дараах эрхийг хэрэгжүүлэх эрх олгоно:

- (1) нислэгийн зааварчилгаа өгөх;
- (2) сурагч-нисгэгчийн өдрийн цагаар үйлдэх анхны бие даасан нислэгээс бусад, бие даасан нислэгийн зөвшөөрөл олгох;
- (3) сурагч-нисгэгчийн шөнийн цагаар үйлдэх анхны бие даасан нислэгээс бусад, бие даасан нислэгийн зөвшөөрөл олгох;
- (4) С-Категорийн багш-нисгэгчийн эрхийн дагуу, нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулахыг шаардсан нисгэгчийн хувьд, тухайн нисгэгч аливаа шаардлагыг хангасан тухай нисгэгчийн дэвтэрт нь тэмдэглэх;
- (5) агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн шалгалт авах.

(i) Энэ зүйлийн (h) нь зөвхөн, тухайн зааварчилгаа, эсхүл үнэлгээ хийхэд ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд, 61.57-гийн дагуу зөвшөөрөл, эсхүл агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг С-Категорийн багш-нисгэгчид хамаарна.

(j) С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг, нислэгийн зааварчилгааны эхний дараалсан 6-гаас доошгүй сар болон минимум эхний 100 цагт дараах А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн шууд хяналтад байгаагаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (h)-д заасан эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн аэродромд, тухайн цаг хугацаанд байгаа;
- (2) хяналтад байгаа багш-нисгэгчийн тухайн нислэгийн зааварчилгааны ажиллагааг шууд хариуцаж байгаа;

(к) Тухайн багш нь дараах хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч байхаас бусад тохиолдолд, С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг хэрэглэлийн нислэгийн цаг агаарын нөхцөлд (IMC), эсхүл ХНД-ийн нислэгийн төлөвлөгөөнд хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн;
- (2) зааварчилгаанд ашиглаж байгаа ойртолтын туслах төхөөрөмж, эсхүл системийн.

(л) Зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгч, тухайн эзэмшигч нь шаардлагатай туршлагатай бөгөөд тухайн ажиллагааны ур чадвараа шалгуулсныг эзэмшигчийн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг дараах зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) шөнийн цагаар; эсхүл
- (2) олон хөдөлгүүрт агаарын хөлөгт; эсхүл
- (3) нисэх онгоцны хувьд, штопор (spinning) эсхүл аэробатик.

В-Категорийн багш-нисгэгч

(м) Энэ зүйлийн (н), (о) болон (р)-г харгалзан, тохирох, хүчинтэй В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид дараах эрхийг олгоно:

- (1) нислэгийн зааварчилгаа өгөх;
- (2) бие даасан нислэгт зөвшөөрөл олгох;
- (3) нисгэгчийн дэвтэрт нь тэмдэглэж баталгаажуулахыг шаардсан нисгэгчийн хувьд, тухайн нисгэгч аливаа шаардлагыг хангасан тухай нисгэгчийн дэвтэрт нь тэмдэглэх;
- (4) агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн шалгалт авах;
- (5) хоёр жилийн нислэгийн үнэлгээ хийх.

(н) Энэ зүйлийн (м) нь зөвхөн, тухайн зааварчилгаа, эсхүл үнэлгээ хийхэд ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд, 61.57-гийн дагуу зөвшөөрөл, эсхүл агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг В-Категорийн багш-нисгэгчид хамаарна.

(о) Тухайн багш нь дараах хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч байхаас бусад тохиолдолд, В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг хэрэглэлийн нислэгийн цаг агаарын нөхцөлд (IMC), эсхүл ХНД-ийн нислэгийн төлөвлөгөөнд хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн;
- (2) зааварчилгаанд ашиглаж байгаа ойртолтын туслах төхөөрөмж, эсхүл системийн.

(р) Зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгч, тухайн эзэмшигч нь шаардлагатай туршлагатай бөгөөд тухайн үйл ажиллагааны ур чадвараа шалгуулсныг, эзэмшигчийн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг дараах зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) шөнийн цагаар; эсхүл
- (2) олон хөдөлгүүрт агаарын хөлөгт; эсхүл
- (3) нисэх онгоцны хувьд, штопор (spinning) эсхүл аэробатик.

А-Категорийн багш-нисгэгч

(q) Энэ зүйлийн (r), (s) болон (t)-г харгалзан, тохирох, хүчинтэй А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид дараах эрхийг олгоно:

- (1) өдрийн, эсхүл шөнийн цагаар нислэгийн зааварчилгаа өгөх;
- (2) өдрийн, эсхүл шөнийн цагаар бие даасан нислэгийн зөвшөөрөл олгох;
- (3) нисгэгчийн дэвтэрт нь тэмдэглэж баталгаажуулахыг шаардсан нисгэгчийн хувьд, тухайн нисгэгч аливаа шаардлагыг хангасан тухай нисгэгчийн дэвтэрт нь тэмдэглэх;
- (4) агаарын хөлгийн маягийн зэрэглэлийн шалгалт авах;
- (5) хоёр жилийн нислэгийн үнэлгээ хийх;
- (6) штопор (spinning) болон аэробатик нислэгийн зааварчилгаа өгөх.

(r) Энэ зүйлийн (q) нь зөвхөн тухайн зааварчилгаа, эсхүл үнэлгээ хийхэд ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн хувьд, 61.57-гийн дагуу зөвшөөрөл, эсхүл маягийн зэрэглэл эзэмшдэг А-Категорийн багш-нисгэгчид хамаарна.

(s) Тухайн багш нь дараах хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч байхаас бусад тохиолдолд, А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг хэрэглэлийн нислэгийн цаг агаарын нөхцөлд (IMC), эсхүл ХНД-ийн нислэгийн төлөвлөгөөнд хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно:

- (1) тухайн тохирох категорин агаарын хөлгийн;
- (2) зааварчилгаанд ашиглаж байгаа ойртолтын туслах төхөөрөмж, эсхүл системийн.

(t) Зохио ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгч, тухайн эзэмшигч нь шаардлагатай туршлагатай бөгөөд тухайн ажиллагааны ур чадвараа шалгуулсныг эзэмшигчийн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг олон хөдөлгүүрт агаарын хөлөгт зааварчилгаа өгөхийг хориглоно.

61.307. Хүчинтэй байх шаардлага

(a) Тухайн багш-нисгэгч нь ижил категорин агаарын хөлгийн хувьд, хүчинтэй ХАА-н зэрэглэлий Зэрэг-1 эзэмшдэг байхаас бусад тохиолдолд, Е-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно.

(b) Тухайн багш-нисгэгч нь хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг байхаас бусад тохиолдолд, D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно.

(c) Тухайн багш-нисгэгч нь хүчинтэй хэрэглэлийн зэрэглэлтэй бөгөөд ХНД-ийн нутаг дамнасан нислэгийн үйл ажиллагаанд хөлгийн даргаар минимум 50 цагийн нислэг үйлдсэнээ шалгагч-нисгэгчээр багш-нисгэгчийн дэвтэртээ тэмдэглүүлснээс бусад тохиолдолд, А, В, С, эсхүл D-Категорийн багш-нисгэгчийн хүчинтэй зэрэглэл эзэмшигчийг ХНД-ээр нутаг дамнасан нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно.

(d) Өмнөх 12 сарын дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, В, эсхүл С-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно:

(1) тухайн багш-нисгэгч нь зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгчид тохирох Категорийн багш-нисгэгчийн нислэгийн шалгалтын хөтөлбөрийн дагуу ур чадвараа шалгуулсан байх;

(2) ур чадварын шалгалт авсан шалгагч-нисгэгч нь, шалгалтыг амжилттай өгснийг 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх.

(e) Өмнөх 24 сарын дотор дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, А, эсхүл E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг нислэгийн зааварчилгаа өгөхийг хориглоно:

(1) тухайн багш-нисгэгч нь зохих ёсоор эрх олгогдсон шалгагч-нисгэгчид тохирох Категорийн багш-нисгэгчийн нислэгийн шалгалтын хөтөлбөрийн дагуу ур чадвараа шалгуулсан байх;

(2) ур чадварын шалгалт авсан шалгагч-нисгэгч нь, шалгалтыг амжилттай өгснийг 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх.

(f) Энэ зүйлийн (d), эсхүл (e)-д шаардсан шалгалтыг, нислэгийн шалгалт өгөхийг шаардсан тухайн өдрийн өмнөх 60 хоногийн дотор өгсөн этгээдийг, тухайн шаардлагыг шаардсан хугацаанд нь хангасанд тооцно.

(g) E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшиж байгаа багш-нисгэгч нь, ХАА-н агаарын хөлгөөр нислэгийн зааварчилгаа өгсөн тухайн цагийг 61.701(b)(2)-ын шаардлагыг хангах нислэгийн цагт тооцож болно.

(h) А, эсхүл В-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн хүчинтэй байх шаардлагыг хангаагүй боловч, доод Категорийн зэрэглэлийн шаардлагыг хангаж байвал тухайн доод Категорийн багш-нисгэгчийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлж болно.

61.309. E-Категорийн багш-нисгэгчийн шилжилтийн зохицуулалт

(a) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл олгогдсон этгээд нь 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс хойш 12 сарын хугацаанд 61.307(e)-гийн дагуу ур чадварын шалгалт өгөхгүйгээр, тухайн зэрэглэлийн эрхийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж болно.

(b) Энэ зүйл нь 2018 оны 12 сарын 31-ний өдөр хүчингүй болно.

Н Бүлэг - Сонирхогч нисгэгчийн үнэмлэх

61.351. Зорилго

Энэ Бүлэг нь сонирхогч нисгэгчийн үнэмлэх олгоход тавих шаардлага, үнэмлэхний эрх, хязгаарлалт болон тухайн нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй байх шаардлагыг тогтооно.

61.353. Тодорхойлолт

Энэ Бүлэгт болон 61.35(b), (d)-д заасан Эрүүл мэндийн тодорхойлолтыг ИНД-67-гийн дагуу Даргын олгосон ЭМГ гэж тооцохгүй.

61.355. Нөхцөл хангах шаардлага

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь сонирхогч-нисгэгчийн үнэмлэх (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг) эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) 17 нас хүрсэн байх;
- (2) В болон С ангиллын жолооны үнэмлэхэнд хамаарах, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олгосон дараах эрүүл мэндийн тодорхойлолттой байх:
 - (i) өмнөх 5 жилийн дотор олгосон; эсхүл
 - (ii) хэрэв тухайн этгээд нь 40, эсхүл түүнээс дээш настай бол, өмнөх 24 сарын дотор олгосон;
- (3) дараах шаардлагыг хангасан байх:
 - (i) Даргын хүлээн зөвшөөрөхүйц бие даасан нислэгийн цаг, хамтарсан нислэгийн цаг, хэрэглэлийн цаг болон нутаг дамнасан нислэгийн цагийг багтаасан минимум 50 цагийн нислэгийн туршлагыг тухайн тохирох категорийн агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэж авсан; эсхүл
 - (ii) хэрэв тухайн этгээд нь нутаг дамнасан нислэгт сонирхогч нисгэгчийн эрхийг хэрэгжүүлэхийг зориогүй бол, Даргын хүлээн зөвшөөрөхүйц бие даасан нислэгийн цаг, хамтарсан нислэгийн цаг болон хэрэглэлийн нислэгийн цагийг багтаасан минимум 40 цагийн нислэгийн туршлагыг тухайн тохирох категорийн агаарын хөлгийн нисгэгчийн үүрэг гүйцэтгэж авсан,
- (4) 61.153(a)(6)-д заасан сэдвийг багтаасан бичгийн шалгалтын хүчинтэй кредиттэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх шалгалтыг амжилттай өгсөн байх;
- (5) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, terrain awareness-ийн сургалтыг амжилттай төгссөн байх;
- (6) тухайн этгээд нь 61.153(a)(7)-гийн дагуу сонирхогч нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын мэдлэгээ шалгуулсан байхаас гадна, хувийн нисгэгчийн үнэмлэх олгох нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх үүрэгтэй.

(b) Хүчинтэй хувийн нисгэгчийн, коммерийн нисгэгчийн, эсхүл агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан бол, тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, сонирхогч нисгэгчийн үнэмлэх авах эрхтэй, хэрэв тухайн этгээд нь:

- (1) энэ зүйлийн (a)(2)-т шаардсан эрүүл мэндийн тодорхойлолт эзэмшдэг байх;
- (2) хэрэв тухайн этгээд 61.39-ийн шаардлагыг 5 жил, эсхүл түүнээс дээш хугацаагаар хангаагүй бол, сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмших хүсэлт гаргаснаас хойш 3 жилийн дотор хувийн нисгэгчийн үнэмлэхний нисэхийн хууль, дүрмийн бичгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.

(c) Дарга, энэ зүйлийн (a)(3)(i)-ийн дагуу нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний нутаг дамнасан нислэгийн туршлагыг бусад категорийн агаарын хөлгийн нутаг дамнасан нислэгийн цагт тооцож болно.

61.357. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, хүчинтэй сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь:

- (1) тухайн нисгэгч агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг, 2000кг, эсхүл түүнээс бага MCTOW-тэй, ганц хөдөлгүүрт, битүүмжлэлгүй нисэх онгоцны хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно; эсхүл
- (2) тухайн нисгэгч агаарын хөлгийн маягийн зэрэглэл эзэмшдэг, 1500кг, эсхүл түүнээс бага MCTOW-тэй, ганц хөдөлгүүрт, нисдэг тэрэгний хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно; эсхүл
- (3) тухайн нисгэгч нь ИНД-67-гийн дагуу олгосон ЭМГ эзэмшдэггүй болохоо зорчигчид мэдээлдэг бол, зорчигч тээвэрлэж болно.

(b) Сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийг дараах үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлөгт хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) Монгол Улсын гадна хийгдэж байгаа үйл ажиллагаанд; эсхүл
- (2) цалинтай (цалинтай ажилтнаар); эсхүл
- (3) 1-ээс дээш зорчигч тээвэрлэх; эсхүл
- (4) хэрэв тухайн агаарын хөлөг нь дараах үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа бол:
 - (i) хөлс болон шан урамшуулалтай; эсхүл
 - (ii) шөнийн цагаар; эсхүл
 - (iii) ХНД-ээр; эсхүл
 - (iv) хяналттай аэродром руу, эсхүл хяналттай аэродромоос, тухайн үнэмлэх эзэмшигч, Даргын хүлээн зөвшөөрөхүйц өнгө ялгах харааны тестийг амжилттай өгснийг нотлох баримтыг Даргад хүргүүлснээс бусад тохиолдолд; эсхүл

- (v) хөөрөлт болон буулт үйлдэхээс бусад тохиолдолд, хот, эсхүл суурингийн шигүү суурьшлын бүс дээгүүр; эсхүл
- (5) хэрэв тухайн агаарын хөлөг нь дараах үйл ажиллагаанд оролцож байгаа бол:
 - (i) иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа; эсхүл
 - (ii) хөлс, эсхүл шан урамшуулалтай глайдер чирэх үйл ажиллагаа; эсхүл
 - (iii) шүхэр хаях үйл ажиллагаа; эсхүл
 - (iv) ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа; эсхүл
 - (v) аэробатик нислэг; эсхүл
 - (vi) тууз/далбаа чирэх үйл ажиллагаа; эсхүл
 - (vii) бай чирэх үйл ажиллагаа, эсхүл
 - (viii) дүүжинт тээврийн үйл ажиллагаа.

61.359. Сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшигчийн эрүүл мэндийн нөхцөлийн өөрчлөлт

Хэрэв сонирхогч нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь эрүүл мэндийн нөхцөлийн аливаа өөрчлөлтөө мэдэж байгаа, эсхүл мэдэж болох бодит шалтгаан байсан, эсхүл, үнэмлэхний эрхээ аюулгүй хэрэгжүүлэхэд нөлөөлөхүйц өмнө нь илэрч байгаагүй аливаа эрүүл мэндийн нөхцөл шинээр илэрсэн бол, нарийн мэргэжлийн эмчлэгч эмч тухайн үнэмлэх эзэмшигч 61.355(а)(2)-ын дагуу ЭМГ эзэмших шаардлага хангаж байгааг бататгахаас бусад тохиолдолд, эзэмшигчийг тухайн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно.

61.361. Хүчинтэй байх шаардлага

Сонирхогчийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь тухайн эзэмшиж байгаа сонирхогчийн нисгэгчийн үнэмлэхний эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.35 (Эрүүл мэндийн шаардлага), 61.37 (Нислэгийн туршлага хадгалах) болон 61.39-д (Хоёр жилийн нислэгийн үнэлгээ) заасан шаардлагыг хангасан байх шаардлагатай.

I Бүлэг - [Нөөц]

J Бүлэг - [Нөөц]

K Бүлэг - [Нөөц]

L Бүлэг - Аэробатикийн зэрэглэл

61.551. Нөхцөл хангах шаардлага

(a) Нисгэгч нь аэробатикийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) дараах эрхийн хүрээнд зохион байгуулсан аэробатикийн газрын бэлтгэлийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх:

(i) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл

(ii) ИНД-149-ийн дагуу олгосон нисэх клубийн гэрчилгээний, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;

(2) дараах эрхийн хүрээнд зохион байгуулсан аэробатик нислэгийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх:

(i) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг бол; эсхүл

(ii) ИНД-149-ийн дагуу олгосон нисэх клубийн гэрчилгээний, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;

(3) дараах этгээдэд штопор (spinning) болон аэробатик нислэгийн ур чадвараа амжилттай шалгуулсан байх:

(i) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчид, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол;

(ii) ИНД-149-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг этгээдэд, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол.

(b) Дараах бичиг баримт эзэмшигчийг энэ зүйлийн (a)(1) болон (2)-ын нөхцөл хангах шаардлагыг хангасанд тооцно:

(1) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй аэробатикийн зэрэглэлтэй байх;

(2) Монгол Улсын зэвсэгт хүчний нисгэгчийн мэргэшилтэй байх.

(c) Хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг ба аэробатикийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахын өмнөх 2 жилийн дотор, Монгол Улсын зэвсэгт хүчний аэробатикийн ур чадварын үнэлгээг амжилттай хийлгэсэн нисгэгчийг энэ зүйлийн (a)-ийн нөхцөл хангах бүх шаардлагыг хангасанд тооцно.

61.553. Зэрэглэл олгох

(а) Хэрэв 61.551-д шаардсан ур чадварын шалгалтыг авсан багш-нисгэгч, эсхүл эрх бүхий этгээд нь тухайн нисгэгчийг 61.551-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, нисгэгчийн дэвтэрт нь дараах мэдэгдлийг оруулж, аэробатикийн зэрэглэл олгож болно:

Би, [үнэлгээ хийсэн огноо]-нд [нисгэгчийн нэр болон үйлчлүүлэгчийн дугаар] нь ИНД-61-д заасан аэробатикийн зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.

Багш-нисгэгчийн, эсхүл зэрэглэл олгох эрх бүхий этгээдийн нэр, гарын үсэг..... / /

Үнэмлэхний дугаар

... он ... сар ... өдөр

(b) Энэ зүйлийн (а)-ийн дагуу олгосон аэробатикийн зэрэглэл эзэмшигч, эсхүл 61.551(с)-гийн шаардлагыг хангасан нисгэгч нь тухайн зэрэглэлээ нисгэгчийн үнэмлэхэндээ баталгаажуулсан тэмдэглэл хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(с) Дарга, энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд аэробатикийн зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

(d) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө нисгэгчийн дэвтэрт баталгаажуулсан тэмдэглэлийн мэдэгдлийг оруулсан бол, 61.551(а)-ийн шаардлагыг хангасанд тооцно.

61.555. Эрх, хязгаарлалт

(а) Эзэмшиж байгаа нисгэгчийн үнэмлэх, эсхүл гэрчилгээний эрх, хязгаарлалтаас хамааран, хүчинтэй аэробатикийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид дараах хязгаарлалтын хүрээнд аэробатикийн маневр гүйцэтгэх эрх олгоно:

- (1) зорчигч тээвэрлэж байгаа үед, газрын гадаргуугаас дээш 1000м-ээс (3000 ft) доошгүй өндөрт;
- (2) зорчигч тээвэрлээгүй үед, газрын гадаргуугаас дээш 500м-ээс (1500 ft) доошгүй өндөрт;
- (3) ИНД-149-ийн дагуу олгосон нисэх клубийн гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрөлтэй, зорчигч тээвэрлээгүй үед, гадаргуугаас 500м-ээс (1500 ft) доош өндөрт, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид нисэх спортын арга хэмжээ зохион байгуулахыг зөвшөөрдөг бол.

61.557. Хүчинтэй байх шаардлага

(а) Дараахаас бусад тохиолдолд, аэробатикийн зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн эзэмшигч нь өмнөх 24 сарын дотор 61.551 (а)(3)-ын шаардлагын дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан байх;

(2) ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл эрх бүхий этгээд ур чадварын шалгалт амжилттай өгснийг 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх.

(b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

М Бүлэг - Глайдер чирэх зэрэглэл

61.601. Нөхцөл хангах шаардлага

(a) Нисгэгч нь глайдер чирэх зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) нисэх онгоцны хөлгийн даргын үүргийг минимум 100 цаг гүйцэтгэсэн байх;
- (2) нисэх клубийн зохион байгуулсан глайдер чирэх курсийг амжилттай төгссөн байх, хэрэв ИНД-149-ийн байгууллагын гэрчилгээ нь эзэмшигчид тухайн курсийг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;
- (3) глайдерын байгууллагын зохих ёсоор эрх олгогдсон этгээдэд глайдер чирэх ур чадвараа амжилттай шалгуулсан байх, хэрэв ИНД-149-ийн байгууллагын гэрчилгээ нь эзэмшигчид тухайн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол.

(b) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй глайдер чирэх зэрэглэл эзэмшигч этгээдийг энэ зүйлийн (a)(2)-ын шаардлагыг хангасанд тооцно.

61.603. Зэрэглэл олгох

(a) Хэрэв 61.601-д шаардсан ур чадварын шалгалт авсан эрх бүхий этгээд нь тухайн нисгэгчийг 61.601-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, дараах мэдэгдлийг нисгэгчийн дэвтэрт нь оруулж, глайдер чирэх зэрэглэл олгож болно:

Би, [үнэлгээ хийсэн огноо]-д, [нисгэгчийн нэр болон үйлчлүүлэгчийн дугаар] нь ИНД-61-д заасан Глайдер чирэх зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.

Зэрэглэл олгосон багш-нисгэгчийн нэр, гарын үсэг...../ /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу глайдер чирэх зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд глайдер чирэх зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

(d) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө нисгэгчийн дэвтэрт баталгаажуулсан тэмдэглэлийн мэдэгдлийг оруулсан бол, 61.601-ийн шаардлагыг хангасанд тооцно.

61.605. Эрх, хязгаарлалт

Хүчинтэй глайдер чирэх зэрэглэл нь тухайн эзэмшигчид, нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтаас хамааран глайдер чирэх үйл ажиллагаанд агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх эрхийг олгоно.

61.607. Хүчинтэй байх шаардлага

(а) Дараахаас бусад тохиолдолд, глайдер чирэх зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор 6-аас доошгүй удаа глайдер чирсэн байх; эсхүл
- (2) тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор 61.601(а)(3)-ын шаардлагын дагуу ур чадвараа шалгуулсан байх;
- (3) ур чадварын шалгалт авсан эрх бүхий этгээд, ур чадварын шалгалт амжилттай өгснийг 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх.

(b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

N Бүлэг - Шүхэр хаях зэрэглэл**61.651. Нөхцөл хангах шаардлага**

(а) Нисгэгч нь шүхэр хаях зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) хүчинтэй хувийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) 200-гаас доошгүй цагийн нислэг үйлдсэн байх, үүний 100-гаас доошгүй цагт нь шүхэр хаях үйл ажиллагаанд ашиглаж байгаа тухайн категорин агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн байх;
- (3) нисэх клубийн зохион байгуулсан шүхэрчин хаях курсийг амжилттай төгссөн байх, хэрэв ИНД-149-ийн байгууллагын гэрчилгээ нь эзэмшигчид тухайн курсийг зохион байгуулахыг зөвшөөрдөг бол;
- (4) шүхрийн байгууллагаас зохих ёсоор эрх олгогдсон этгээдэд шүхэрчин хаях ур чадвараа шалгуулсан байх, хэрэв ИНД-149-ийн байгууллагын гэрчилгээ нь эзэмшигчид үнэлгээ хийхийг зөвшөөрдөг бол.

(b) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хүчинтэй шүхэр хаях зэрэглэлтэй нисгэгчийг энэ зүйлийн (а)(3)-т заасан шаардлагыг хангасанд тооцно.

61.653. Зэрэглэл олгох

(a) Хэрэв 61.651(а)-д шаардсан ур чадварын шалгалт авсан эрх бүхий этгээд нь тухайн нисгэгчийг 61.651-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, дараах мэдэгдлийг нисгэгчийн дэвтэрт нь оруулж, шүхэр хаях зэрэглэл олгож болно:

Би, [үнэлгээ хийсэн огноо]-д, [нисгэгчийн нэр болон үйлчлүүлэгчийн дугаар] нь ИНД-61-д заасан Шүхэр хаях зэрэглэл (нисэх онгоц), (нисдэг тэрэг) олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.

Зэрэглэл олгосон багш-нисгэгчийн нэр, гарын үсэг...../ /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон шүхэр хаях зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд шүхэр хаях зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэлийг хийж болно.

(d) Нисгэгчийн дэвтэрт 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө баталгаажуулсан тэмдэглэлийн мэдэгдлийг оруулсан бол, 61.651(а)-ийн шаардлагыг хангасанд тооцно.

61.655. Эрх, хязгаарлалт

Хүчинтэй шүхэр хаях зэрэглэл нь тухайн эзэмшигчид, нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтаас хамааран шүхэр хаях үйл ажиллагаанд оролцож байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх эрх олгоно.

61.657. Хүчинтэй байх шаардлага

(a) Шүхэр хаях зэрэглэл эзэмшигчийг, дараахаас бусад тохиолдолд, тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор 6-аас доошгүй удаа шүхэр хаясан байх; эсхүл
- (2) тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор 61.651 (a)(4)-ийн шаардлагын дагуу ур чадварын хадгалалтаа амжилттай шалгуулсан байх;
- (3) ур чадварын шалгалт авсан тухайн эрх бүхий этгээд, ур чадварын шалгалт амжилттай өгснийг 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх.

(b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

О Бүлэг - ХАА-н зэрэглэл

61.701. Нөхцөл хангах шаардлага

(a) Аливаа этгээд нь нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний ХАА-н зэрэглэлийн Зэрэг-2 эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй хувийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) ХАА-н зэрэглэл эзэмших сургалтад хамрагдахаас өмнө, тухайн тохирох категорийн агаарын хөлгийн даргын минимум 100 цагийг багтаасан, минимум 200 цаг нисгэгчийн үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цагийн туршлагатай байх;
- (3) ХАА-н газрын бэлтгэлийн болон нислэгийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх;
- (4) [Хүчингүй]
- (5) [Хүчингүй]
- (6) нисгэгчийн химийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (7) дараах нэг, эсхүл хэд хэдэн зэрэглэлийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх:
- (8) агаараас бордоо цацах зэрэглэл;
- (9) агаараас шингэн цацах зэрэглэл;
- (10) агаараас мэргэчийн хор цацах зэрэглэл; болон
- (11) тохирох, хүчинтэй ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшиж байгаа шалгагч-нисгэгчид ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааны ур чадвараа амжилттай шалгуулсан байх.

(b) Аливаа этгээд нь нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэгний ХАА-н зэрэглэлийн Зэрэг-1 эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн даргын минимум 200 цагийг багтаасан, агаарын хөлгөөс ХАА-н химийн, эсхүл ХАА, цэцэрлэгжүүлэлт, ой мод хамгаалах бодис цацах нислэгийн үйл ажиллагаанд оролцсон минимум 1000 цагийн бодит үйлдвэрлэлийн нислэгийн цагийн туршлагатай байх;
- (3) тохирох, хүчинтэй ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшиж байгаа шалгагч-нисгэгчид, ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааны ур чадвараа амжилттай шалгуулсан байх.

(c) Энэ зүйлийн (a)(3)-т шаардсан сургалт болон (a)(8), (b)(3)-т шаардсан ур чадварын шалгалтыг дараах эрхийн хүрээнд гүйцэтгэсэн байх үүрэгтэй:

- (1) гэрчилгээ нь үйл ажиллагаа эрхлэгчид тухайн сургалт, эсхүл ур чадварын үнэлгээ хийхийг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний; эсхүл
- (2) гэрчилгээ нь үйл ажиллагаа эрхлэгчид тухайн сургалт, эсхүл ур чадварын үнэлгээ хийхийг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний.

61.703. Зэрэглэл олгох

(a) Хэрэв 61.701(a)(8), эсхүл (b)(3)-т шаардсан ур чадварын шалгалт авсан шалгагч-нисгэгч, тухайн этгээдийг ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх чадвартай гэж үзвэл, тухайн шалгагч-нисгэгч нь дараах үүрэгтэй:

- (1) нислэгийн шалгалтын тайлангийн хувийг Даргад хүргүүлэх;
- (2) тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулах:

Би, [үнэлгээ хийсэн огноо], [нисгэгчийн нэр болон үнэмлэхний дугаар] нь ХАА-н зэрэглэлийн (Зэрэг-1) (Зэрэг-2)*-ийн (нисэх онгоц)* (нисдэг тэрэг)*-ний (агаараас бордоо цацах)* (агаараас шингэн цацах)* (агаараас мэрэгчийн хор цацах)* зэрэглэл олгоход тавих ур чадвараа ИНД-ийн (61.701(a)(8))* (61.701(b)(3))*-ийн дагуу ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд шалгуулсан болохыг тодорхойлж байна.*

Шалгагч-нисгэгчийн нэр, гарын үсэг...../ /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

** хамааралгүйг нь устгах*

(b) [Хүчингүй]

(c) Энэ зүйлийн (a)(2)-ын дагуу нисгэгчийн дэвтэртээ тэмдэглэл хийлгэсэн этгээд нь тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийн өмнө 61.11(a)-ийн дагуу ХАА-н зэрэглэл эзэмших хүсэлтийг Даргад гаргах үүрэгтэй.

(d) Дарга энэ зүйлийн (c)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд ХАА-н зэрэглэлийн баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

(e) [Хүчингүй]

(f) [Хүчингүй]

(g) [Хүчингүй]

61.705. Эрх, хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, ИНД-137 болон нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтын хүрээнд, хүчинтэй ХАА-н зэрэглэл эзэмшигч нь ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.

(b) Хэрэв ИНД-137-гийн дагуу, гуравдагч этгээдэд эрсдэлтэй бол, ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлөгт ХАА-н зэрэглэлийн зэрэг-2 эзэмшигчийг агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

61.707. Хүчинтэй байх шаардлага

(a) Энэ зүйлийн (d)-г харгалзан, дараахаас бусад тохиолдолд, ХАА-н зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) өмнөх 12 сарын дотор, E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч, эсхүл ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчид тохирох агаарын хөлгийн категорит, хэрэгжүүлэхээр зорьж байгаа ХАА-н зэрэглэлд хамаарах ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааг гүйцэтгэх ур чадвараа амжилттай шалгуулсан байх;
- (2) тухайн ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч нь тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулсан байх:

Би, [үнэлгээ хийсэн огноо], [нисгэгчийн нэр болон үнэмлэхний дугаар] нь ХАА-н зэрэглэлийн (Зэрэг-1) (Зэрэг-2)*-ийн (нисэх онгоц)* (нисдэг тэрэг)*-ийн хүчинтэй байдлын хадгалалтаа (агаараас бордоо цацах)* (агаараас шингэн цацах)* (агаараас мэрэгчийн хор цацах)* үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагааны ур чадвараа ИНД-ийн (61.707(a)(1)-ийн дагуу шалгуулсан болохыг тодорхойлж байна.*

Дараагийн ур чадварын шалгалтыг [үнэлгээ хийлгэсэн өдрөөс хойш 12 сар, эсхүл (c)-гийн дагуу хугацаа дуусах өдрөөс хойш 12 сарын аль сүүлчийнхээр] өгсөн байна.

*Багш-нисгэгчийн, эсхүл Шалгагч-нисгэгчийн нэр, гарын үсэг / /
Үнэмлэхний дугаар*

он ... сар ... өдөр

*(*хамааралгүйг нь устгах)*

(b) Шалгалт өгөхийг шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

(ba) Ур чадварын шалгалт авсан тухайн багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч нь холбогдох САА маягыг бөглөж, хувийг Дарга болон тухайн нисгэгчид хүргүүлэх үүрэгтэй.

(c) Хэрэв ИНД-137-гийн дагуу, гуравдагч этгээдэд эрсдэл учруулах бол, дараахаас бусад тохиолдолд, ХАА-н зэрэглэлийн Зэрэг-1 эзэмшигчийг агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) эзэмшигч нь ашиглагдаж байгаа тухайн маягийн агаарын хөлгийн даргын 25-аас доошгүй цагийн нислэгийн туршлагатай байх;
- (2) тухайн шаардсан нислэгийн цагийн 10 цагийг өмнөх 12 сарын дотор үйлдсэн байх;

(d) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, хүчинтэй нисгэгчийн химийн зэрэглэл эзэмшдэг байхаас бусад тохиолдолд, ХАА-н зэрэглэл эзэмшигчийг ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд агаарын хөлгөөс химийн бодис цацахыг хориглоно.

61.709. ХАА-н зэрэглэлийн шилжилтийн нөхцөл

(a) Энэ зүйл нь 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө олгосон хүчинтэй ХАА-н зэрэглэлд хамаарна.

(b) Энэ зүйлд хамаарах зэрэглэл эзэмшдэг нисгэгч нь дараах тохиолдолд, тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлж болно:

- (1) 61.707-гийн дагуу нисгэгчийн ур чадварын шалгалт өгөх хугацаа дуусах өдөр хүртэл, хэрэв тухайн нисгэгч хүчинтэй химийн зэрэглэл эзэмшдэг бол:
- (2) 61.707-гийн дагуу нисгэгчийн ур чадварын шалгалт өгөх хугацаа дууссан өдрөөс хойш, хэрэв-
 - (i) тухайн нисгэгч тогтоосон хугацаанд 61.707-гийн дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан бол;
 - (ii) тухайн нисгэгч нь 61.11(a)-ийн дагуу ХАА-н зэрэглэл эзэмших хүсэлтийг Даргад гаргасан бол;
 - (iii) Дарга хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч, өөрийн шийдвэрээр ХАА-н зэрэглэл олгосон бол.

(c) Энэ зүйлийн (b)(2)-ыг үл харгалзан, нисгэгч энэ зүйлд хамаарах зэрэглэлийн эрхийг, Даргад энэ зүйлийн (b)(2)(ii)-ын дагуу хүсэлт гаргаснаас хойш 30 хоногоос хэтрүүлэхгүйгээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж болно.

61.710. Баталгаажуулах зөвшөөрөл

Энэ дүрмийн 61.701(a), эсхүл (b)-д шаардсан нисгэгчийн үнэмлэхтэй дүйцэх гадаадын нисгэгчийн үнэмлэхний хүчинтэй баталгаажуулах зөвшөөрөл эзэмшдэг этгээд болон 61.701-ийн дагуу ХАА-н зэрэглэлтэй дүйцнэ гэж Даргын зөвшөөрсөн мэргэшил эзэмшдэг этгээд нь дүйцэх ХАА-н зэрэглэлээ баталгаажуулах зөвшөөрөлд баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр 61.11(a)-ийн дагуу Даргад хүсэлт гаргаж болно.

ОА Бүлэг - Агаараас бордоо цацах зэрэглэл

61.711. Нөхцөл хангах шаардлага

Аливаа этгээд нь агаараас бордоо цацах зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй ХАА-н зэрэглэлийн Зэрэг-2 эзэмшдэг байх;
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас шингэн цацах зэрэглэлийн сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд зохион байгуулсан газрын бэлтгэл сургалт болон агаараас шингэн цацах үйл ажиллагааны нислэгийн зааварчилгаанаас бүрдсэн сургалтын курсийг амжилттай төгссөн байх;
- (3) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас шингэн цацах зэрэглэлийн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа E-Категорийн багш-нисгэгчид, эсхүл ХАА-н шалгагч-нисгэгчид агаараас шингэн цацах ур чадвараа ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж амжилттай шалгуулсан байх.

61.713. Зэрэглэл олгох

(a) Хэрэв ИНД-61.711(3)-т шаардсан ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч нь тухайн нисгэгчийг 61.711-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, агаараас бордоо цацах зэрэглэл олгож, нисгэгчийн дэвтэрт нь дараах мэдэгдлийг оруулж болно:

Би, (үнэлгээ хийсэн огноо) [нисгэгчийн нэр болон үнэмлэхний дугаар] нь агаараас бордоо цацах зэрэглэл (нисэх онгоц) (нисдэг тэрэг)* олгоход тавих ИНД-61-ийн шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.*

Зэрэглэл олгосон багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчийн нэр, гарын үсэг..... / /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

(b) Агаараас бордоо цацах зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

61.715. Эрх, хязгаарлалт

Тухайн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтаас хамааран, ХАА-н зэрэглэл болон агаараас бордоо цацах зэрэглэл эзэмшигч нь агаараас бордоо цацах үйл ажиллагаанд оролцож байгаа тохирох категорийн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.

61.717. Хүчинтэй байх шаардлага

(a) Тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор ИНД-61.711(3)-ын дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан ба ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч, тухайн шалгалтыг амжилттай өгснийг тухайн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, агаараас бордоо цацах зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно.

(b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

61.719. ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн зохицуулалт

(a) Энэ зүйл нь 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө олгосон хүчинтэй ХАА-н зэрэглэлд хамаарна.

(b) Энэ зүйлд хамаарах зэрэглэл эзэмшдэг нисгэгч нь хэрэв хүчинтэй химийн зэрэглэл эзэмшдэг бол, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусах хүртэл ИНД-61.715-д заасан эрхийг хэрэгжүүлж болно.

(c) Энэ зүйлийн (b)-д заасан нисгэгчид, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө 61.717-гийн дагуу ур чадварын шалгалтаа амжилттай өгсөн бол:

- (1) 61.711(2)-ын шаардлага хангасанд тооцно;
- (2) агаараас бордоо цацах зэрэглэл олгож болно.

ОВ Бүлэг - Агаараас шингэн цацах зэрэглэл**61.721. Нөхцөл хангах шаардлага**

Нисгэгч нь агаараас шингэн цацах зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй ХАА-н зэрэглэлийн Зэрэг-2 эзэмшдэг байх;
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас шингэн цацах зэрэглэлийн сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд зохион байгуулсан газрын бэлтгэл сургалт болон агаараас шингэн цацах үйл ажиллагааны нислэгийн зааварчилгаанаас бүрдсэн сургалтын курсийг амжилттай төгссөн байх;

- (3) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас шингэн цацах зэрэглэлийн үнэлгээ хийхийг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа E-Категорийн багш-нисгэгчид, эсхүл ХАА-н шалгагч-нисгэгчид агаараас шингэн цацах ур чадвараа ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаа гүйцэтгэж амжилттай шалгуулсан байх.

61.723. Зэрэглэл олгох

- (a) Хэрэв ИНД-61.721(3)-т шаардсан ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч нь тухайн нисгэгчийг 61.721-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, агаараас шингэн цацах зэрэглэл олгож, тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулж болно:

Би, (үнэлгээ хийсэн огноо) [нисгэгчийн нэр болон үйлчлүүлэгчийн дугаар] нь агаараас шингэн цацах зэрэглэл (нисэх онгоц) (нисдэг тэрэг)* олгоход тавих ИНД-61-ийн шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.*

Зэрэглэл олгосон багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчийн нэр, гарын үсэг..... / /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

- (b) Агаараас шингэн цацах зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

- (c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд агаараас шингэн цацах зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

61.725. Эрх

Тухайн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтаас хамааран, ХАА-н зэрэглэл болон агаараас шингэн цацах зэрэглэл эзэмшигч нь агаараас шингэн цацах үйл ажиллагаанд оролцож байгаа тохирох категорийн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.

61.727. Хүчинтэй байх шаардлага

- (a) Тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор ИНД-61.721(3)-ын дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан ба ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч, тухайн шалгалтыг амжилттай өгснийг тухайн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, агаараас шингэн цацах зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно.

- (b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

61.729. ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн зохицуулалт

(a) Энэ зүйл нь 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө олгосон хүчинтэй ХАА-н зэрэглэлд хамаарна.

(b) Энэ зүйлд хамаарах зэрэглэл эзэмшдэг нисгэгч нь хэрэв хүчинтэй химийн зэрэглэл эзэмшдэг бол, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусах хүртэл ИНД-61.725-д заасан эрхийг хэрэгжүүлж болно.

(c) Энэ дүрмийн 61.727(b)-д заасан, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ур чадварын шалгалтаа амжилттай өгсөн нисгэгчийг:

- (1) 61.721(2)-ын шаардлага хангасанд тооцох, ба
- (2) агаараас шингэн цацах зэрэглэл олгож болно.

ОС Бүлэг - Агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл**61.731. Нөхцөл хангах шаардлага**

Нисгэгч нь агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, ХАА-н зэрэглэлийн Зэрэг-2 эзэмшдэг байх;
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас мэрэгчийн хор цацах сургалтын курс зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд зохион байгуулсан агаараас мэрэгчийн хор цацах үйл ажиллагааны газрын бэлтгэл сургалт болон нислэгийн зааварчилгаанаас бүрдсэн сургалтын курсийг амжилттай төгссөн байх;
- (3) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын, эсхүл гэрчилгээ нь эзэмшигчдээ агаараас мэрэгчийн хор цацах ур чадварын үнэлгээ хийхийг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа E-Категорийн багш-нисгэгчид, эсхүл ХАА-н шалгагч-нисгэгчид агаараас мэрэгчийн хор цацах ур чадвараа амжилттай шалгуулсан байх.

61.733. Зэрэглэл олгох

(a) Хэрэв ИНД-61.731(3)-т шаардсан ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч нь тухайн нисгэгчийг 61.731-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл олгож, тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулж болно:

Би, (үнэлгээ хийсэн огноо) [нисгэгчийн нэр болон үйлчлүүлэгчийн дугаар] нь агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл (нисэх онгоц) (нисдэг тэрэг)* олгоход тавих ИНД-61-ийн шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.*

Зэрэглэл олгосон багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгчийн нэр, гарын үсэг..... / /

Үнэмлэхний дугаар он ... сар ... өдөр

(хамааралгүйг нь хасах)*

(b) Агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

61.735. Эрх

Тухайн нисгэгчийн үнэмлэхний эрх, хязгаарлалтаас хамааран, хүчинтэй ХАА-н зэрэглэл болон агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшигч нь агаараас мэрэгчийн хор цацах үйл ажиллагаанд оролцож байгаа тохирох категорин агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэж болно.

61.737. Хүчинтэй байх шаардлага

(a) Тухайн эзэмшигч нь өмнөх 12 сарын дотор ИНД-61.731(3)-ын дагуу ур чадвараа амжилттай шалгуулсан ба ур чадварын шалгалт авсан багш-нисгэгч, эсхүл шалгагч-нисгэгч, тухайн шалгалтыг амжилттай өгснийг тухайн нисгэгчийн дэвтэрт баталгаажуулснаас бусад тохиолдолд, агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно.

(b) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор ур чадварын шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

61.739. ХАА-н зэрэглэл эзэмшигчийн шилжилтийн нөхцөл

(a) Энэ зүйл нь 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө олгосон хүчинтэй ХАА-н зэрэглэлд хамаарна.

(b) Энэ зүйлд хамаарах зэрэглэл эзэмшдэг нисгэгч нь хэрэв хүчинтэй химийн зэрэглэл эзэмшдэг бол, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусах хүртэл 61.735-д заасан эрхийг хэрэгжүүлж болно.

(c) Энэ дүрмийн 61.737(b)-д заасан, ХАА-н зэрэглэлийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө ур чадварын шалгалтаа амжилттай өгсөн нисгэгчийг:

(1) 61.731(2)-ын шаардлага хангасанд тооцно,

(2) агаараас мэрэгчийн хор цацах зэрэглэл олгож болно.

Р Бүлэг - Нисгэгчийн химийн зэрэглэл

61.751. Нөхцөл хангах шаардлага

(a) Нисгэгч нь химийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, хүчинтэй хувийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч байх;
- (2) дараах эрхийн хүрээнд хийсэн ХАА-н химийн бодис хэрэглэх сургалтын курсийг амжилттай төгсөж, үнэлгээ хийлгэсэн байх:
 - (i) гэрчилгээ нь үйл ажиллагаа эрхлэгчид тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний; эсхүл
 - (ii) гэрчилгээ нь байгууллагад тухайн сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний.

61.753. Зэрэглэл олгох

(a) Хэрэв нисгэгч нь 61.751-ийн нөхцөл хангах шаардлагыг хангасан бол, 61.751-д шаардсан үнэлгээ хийсэн этгээд нь нисгэгчийн химийн зэрэглэл олгож, 61.29-ийн дагуу тухайн нисгэгчийн дэвтэрт дараах мэдэгдлийг оруулж болно:

Би энэ мэдэгдлээр [нисгэгчийн нэр] нь ИНД-61-д заасан нисгэгчийн химийн зэрэглэл олгоход тавих шаардлагыг хангасан болохыг тодорхойлж байна.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон химийн зэрэглэл эзэмшигч нь тухайн зэрэглэлээ баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(c) Дарга энэ зүйлийн (b)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд химийн зэрэглэлийг баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

61.755. Эрх

Хүчинтэй нисгэгчийн химийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид ИНД-137-гийн дагуу ХАА-н агаарын хөлгийн үйл ажиллагаанд агаарын хөлгөөс ХАА-н химийн бодис цацах эрхийг олгоно.

61.757. Хүчинтэй байх шаардлага

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн зэрэглэл олгосноос хойш 5 жилийн дараа, дараах шаардлагыг хангаагүй нисгэгчийн химийн зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн эзэмшигч нь өмнөх 5 жилийн дотор Даргын хүлээн зөвшөөрөхүйц сэргээх сургалтын курсийг амжилттай төгссөн байх;

(2) тухайн сургалтын холбогдох бүртгэлийг 61.29-ийн дагуу нисгэгчийн дэвтэртээ тэмдэглүүлсэн байх.

(b) Шаардсан өдрөөс өмнө 90 хоногийн дотор энэ зүйлийн (a)-д шаардсан сэргээх сургалтыг амжилттай төгссөн нисгэгчийг тухайн сургалтыг шаардсан хугацаанд нь хийсэнд тооцно.

Q Бүлэг - Хэрэглэлийн зэрэглэл

61.801. Нөхцөл хангах шаардлага

(a) Энэ зүйлийн (b) болон (c)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд нь хэрэглэлийн зэрэглэл (нисэх онгоц, эсхүл нисдэг тэрэг) эзэмшихийн тулд тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тухайн тохирох категорин агаарын хөлгийн хувьд, шөнийн нислэг үйлдэх эрх бүхий хүчинтэй нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн цагийн туршлагатай байх;
- (3) дараах сэдвээр газрын бэлтгэл сургалтын курсийг амжилттай төгссөн байх:
 - (i) нисэхийн хууль дүрэм: ХНД-ээр үйлдэх нислэгтэй холбоотой дүрэм, журам; нислэгийн хөдөлгөөний үйлчилгээтэй холбоотой практик хэрэглээ болон журам; ХНД-ээр үйлдэх нислэгтэй холбоотой нислэгийн өмнөх бэлтгэл болон үзлэг; нислэгийн үйл ажиллагааны төлөвлөлт; ХНД-ээр үйлдэх нислэгийн төлөвлөгөөг бэлтгэх болон бүрдүүлэх; өндөр-хэмжигчийг тохируулах журам; AIP, NOTAM, нисэхийн код болон товчлол зэрэг нисэхийн бичиг баримтын тайлбар болон хэрэглээ, нисэн гарах, замын, өндөр алдах болон ойртолт үйлдэх хэрэглэлийн нислэгийн журмын зураг; урьдчилан сэргийлэх болон онцгой нөхцөлийн журам; ХНД-ээр үйлдэх нислэгтэй холбоотой аюулгүй байдлын практик дадлага; ХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн үйл ажиллагаанд хэрэглэдэг радио-холбооны журам болон фразеолог/стандарт хэллэг; холбоо ажилгүй болсон үед авах арга хэмжээ;
 - (ii) нислэгийн навигаци-ХНД: радио навигацийн туслах төхөөрөмж ашиглан агаарын навигаци хийх практик дадлага; нисэн гарах, чиглэлийн нислэг, ойртолт үйлдэх болон буулт үйлдэх нислэгийн үе шатуудад навигацийн систем ашиглах, түүний нарийвчлал болон найдвартай ажиллагаа; радио навигацийн туслах төхөөрөмжийг таньж тогтоох;

- (iii) цаг уур: нисэхийн цаг уурын тайлан мэдээ, зураг болон цаг уурын урьдчилсан мэдээг тайлж унших болон ашиглах; нислэгийн өмнө ба нислэгийн үед цаг уурын мэдээ авах журам ба түүнийг ашиглах; өндөр хэмжих; нисэхийн цаг уур судлал; тухайн бүс нутгийн нислэгт нөлөөлж болзошгүй элементийг хамарсан цаг агаар судлал; хөөрөлт, чиглэлийн нислэг болон буултын нөхцөлд нөлөөлж болох даралтын системийн хөдөлгөөн, фронтын бүтэц болон цаг агаарын онцгой үзэгдлийн үүсэл, тэдгээрийн шинж чанар; цаг агаарын аюултай нөхцөлөөс зайлсхийх;
 - (iv) хэрэглэлийн болон навигацийн туслах төхөөрөмж: хэрэглэлийн нислэгийн цаг уурын нөхцөлд, ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлгийн хяналт, навигацид шаардлагатай авионик болон хэрэглэл ашиглах, тэдгээрийн хязгаарлалт, ажиллагаатай байдал; автопилотын хэрэглээ болон түүний хязгаарлалт; компас, түүний эргэлтийн болон заалтын хурдны алдаа; гироскопын хэрэглэлүүд, тэдгээрийн ашиглалтын хязгаарлалт болон нарийвчлалын нөлөө; навигацийн хэд хэдэн нислэгийн хэрэглэлийн доголдолтой ажиллах үед мөрдөх журам ба дадлага;
 - (v) хүний хүчин зүйл: хүний боломж болон хязгаарлалт.
- (4) тохирох категорийн агаарын хөлгөөр, зохих ёсоор мэргэшсэн багш-нисгэгчийн зохион байгуулсан, дараах сэдвийг багтаасан минимум 10 цагийн хосолсон нислэгийн зааварчилгаатай нислэгийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх:
- (i) нислэгийн заавар, эсхүл дүйцэх баримт бичиг болон ХНД-ийн нислэгийн төлөвлөгөөг бэлтгэхтэй холбоотой нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний баримт бичгийг ашиглах журмыг багтаасан нислэгийн өмнөх журам;
 - (ii) нислэгийн өмнөх үзлэг, шалгах хуудсыг ашиглах, явгалалт болон хөөрөлтийн өмнөх үзлэг;
 - (iii) хэвийн, хэвийн бус болон онцгой нөхцөлийг хамарсан ХНД-ийн нислэгийн үеийн журам болон маневр үүнд: хөөрөлтийн үед хэрэглэлийн нислэгт шилжих; стандарт хэрэглэлээр нисэн гарах болон нисэн ирэх; замын ХНД-ийн журам; хүлээлтийн журам; тодорхой өгөгдсөн минима хүртэл хэрэглэлийн ойртолт үйлдэх; ойртолтоос 2-т гарах журам (missed approach procedure); хэрэглэлийн ойртолтоор буулт үйлдэх зэрэг үйлдлийг багтаасан;
 - (iv) нислэгийн үеийн маневр болон тодорхой нислэгийн үзүүлэлтүүд;
 - (v) олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд, нэг хөдөлгүүр ажиллагаагүй болсон, эсхүл ажиллагаагүй болсон нөхцөлийг зохиомлоор үүсгэсэн үед зөвхөн хэрэглэл ашиглан агаарын хөлгийг удирдах;
- (5) энэ зүйлийн (а)(3)-т заасан сэдвээр зөвшөөрөгдсөн бичгийн шалгалтыг хамарсан бичгийн шалгалтын хүчинтэй, эсхүл зөвшөөрөгдсөн дүйцэх кредиттэй байх;

(б) Даргад (тохирох агаарын хөлөг, эсхүл зөвшөөрөгдсөн синтетик дадлагажуур дээр нислэгийн шалгалт өгч) тухайн хүсэлт гаргагчийн шалгуулж байгаа навигацийн системтэй хамааралтай, энэ зүйлийн (а)(4)-т заасан журам, маневр болон үйл ажиллагааг гүйцэтгэх ур чадвар болон дараах ур чадвараа амжилттай шалгуулсан байх:

- (i) агаарын хөлгөөр түүний хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа эрхлэх;
- (ii) бүх маневрыг жигд, нямбай гүйцэтгэх;
- (iii) оновчтой шийдвэр гаргах болон нисгэгчийн ур чадвар;
- (iv) нисэхийн мэдлэгээ ашиглах;
- (v) нислэгийн журам, эсхүл маневрын амжилттай гүйцэтгэлд хэзээ ч эргэлзээ төрөхгүй байх хэлбэрээр нислэгийн туршид тухайн агаарын хөлгийг итгэлтэй удирдах.

(б) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч Улсаас олгосон хязгаарлалтгүй дүйцэх зэрэглэл эзэмшигч нь хэрэглэлийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) энэ зүйлийн (а)(3)(i)-ийн дагуу тогтоосон нисэхийн хууль, дүрмийн сэдвээр бичгийн шалгалтын кредиттэй байх;
- (2) энэ зүйлийн (а)(6)-д шаардсан нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх.

(с) Монгол Улсын зэвсэгт хүчний хэрэглэлийн зэрэглэл эзэмшдэг бөгөөд хэрэглэлийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас 3 сарын өмнө Монгол Улсын зэвсэгт хүчний хэрэглэлийн нислэгийн үнэлгээг амжилттай хийлгэсэн этгээдийг энэ зүйлийн (а)(2)-оос (а)(6) хүртэлх нөхцөл хангах шаардлагыг хангасанд тооцно.

61.803. Зэрэглэл олгох

(а) Хэрэглэлийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч 61.801-ийн шаардлагыг хангасан гэж үзвэл, Дарга тухайн нисгэгчийн үнэмлэхэнд баталгаажуулсан тэмдэглэл хийн, зэрэглэл олгож болно.

(б) Хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч нь ойртолтын нэмэлт туслах төхөөрөмж, эсхүл системийн баталгаажуулсан тэмдэглэлийг нисгэгчийн үнэмлэхэндээ хийлгэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(с) Дарга энэ зүйлийн (б)-гийн дагуу гаргасан хүсэлт болон зохих төлбөрийн баримтыг хүлээн авч тухайн нисгэгчийн үнэмлэхэнд ойртолтын нэмэлт туслах төхөөрөмжийн, эсхүл системийн баталгаажуулсан тэмдэглэл хийж болно.

61.805. Эрх, хязгаарлалт

(а) Энэ зүйлийн (б)-г харгалзан, хүчинтэй хэрэглэлийн зэрэглэл нь тухайн эзэмшигчид, ХНД-ээр үйл ажиллагаа явуулж байгаа тохирох агаарын хөлгийн даргын, эсхүл хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэх эрхийг олгоно.

(б) Хэрэглэлийн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд түүнийг эзэмшигч нь дараах үүрэгтэй:

- (1) ганц нисгэгчтэй агаарын хөлгийн хувьд, 61.801 (a)(6), эсхүл 61.801(c)-д шаардсан ганц нисгэгчийн үйл ажиллагааны стандартын дагуу нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн байх;
- (2) татах хүч нь үндсэн тэнхлэг дээр байрлаагүй, олон хөдөлгүүрт нисэх онгоцны хувьд, 61.801(a)(6), эсхүл 61.801(c)-д шаардсан нислэгийн шалгалтыг, татах хүч нь үндсэн тэнхлэг дээр байрлаагүй, олон хөдөлгүүрт нисэх онгоцоор амжилттай өгсөн байх;
- (3) хэрэв тухайн эзэмшигч нь ХНД-ийн дагуу, хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг ашиглаж байгаа бол, шалгагч-нисгэгч тухайн эзэмшигч ойртолтын туслах төхөөрөмж, эсхүл системийн ур чадвараа амжилттай шалгуулсныг тухайн нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх;
- (4) хэрэв тухайн эзэмшигч нь зөвхөн 2-р ангиллын ЭМГ эзэмшдэг бол, ИНД-67-д заасан 1-р ангиллын сонсголын шаардлагыг хангасан байх ёстой ба 2-р ангиллын ЭМГ-нд баталгаажуулсан тэмдэглэл хийлгэсэн байх.

61.807. Хүчинтэй байх шаардлага

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, дараах шаардлагыг хангаагүй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно:

- (1) өмнөх 12 сарын дотор:
 - (i) тухайн тохирох категорийн агаарын хөлгийн хувьд, 61.801(a)(6)-гийн дагуу шалгагч-нисгэгчид, ур чадвараа амжилттай шалгуулсан байх;
 - (ii) ур чадварын шалгалт авсан этгээд нь, тухайн ур чадварын шалгалтыг амжилттай өгснийг 61.29-ийн дагуу нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан байх;
- (2) өмнөх 3 сарын дотор:
 - (i) энэ зүйлийн (a)(1)-ийн шаардлагыг хангасан, эсхүл 3-аас доошгүй хэрэглэлийн нислэгийн цаг (үүний 1-ээс доошгүй цаг нь хэрэглэлээр ниссэн байх);
 - (ii) 3-аас доошгүй удаа зарласан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг гүйцэтгэсэн байх (үүний 1 нь зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуур дээр гүйцэтгэсэн байж болно);
- (3) хэрэв татах хүч нь гол тэнхлэг дагуу байрлаагүй олон хөдөлгүүрт агаарын хөлгийн нисгэгчийн үүргийг ХНД-ээр гүйцэтгэх бол, энэ зүйлийн (a)(1)-д шаардсаны дагуу ур чадварын шалгалт өгсөн байх;
- (4) хэрэв ХНД-ийн дагуу хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг ашиглах бол, өмнөх 3 сарын дотор, нислэгт, эсхүл зөвшөөрөгдсөн синтетик нислэгийн дадлагажуур дээр төстэй маягийн навигацийн системийг ашиглан тогтоосон хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг гүйцэтгэсэн байх;

(5) хэрэв ИНД-119-ийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд, ХНД-ийн үйл ажиллагаа эрхлэх бол, ИНД-121, 125, эсхүл 135-ын ХНД-ийн ур чадварын шаардлагын аль хамааралтайг нь хангасан байх.

(b) Хэрэв тухайн агаарын хөлөг нь иргэний агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгээгүй бол, энэ зүйлийн (a)(2)-ын шаардлагыг хангаагүй хэрэглэлийн зэрэглэл эзэмшигч нь, ХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хамтран нисгэгчийн үүрэг гүйцэтгэж болно.

(c) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор энэ зүйлийн (a)(1)-д шаардсан шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

R Бүлэг - Нөөц

S Бүлэг - Шалгагч-нисгэгчийн зэрэглэл

61.901. Нөхцөл хангах шаардлага

(a) Аливаа этгээд нь шугамын агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) ИНД-125 болон ИНД-135-ын дагуух үйл ажиллагааны хувьд, тохирох коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) ИНД-121-ийн дагуух үйл ажиллагааны хувьд, агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх (нисэх онгоц) эзэмшдэг байх;
- (3) хүчинтэй А, В, эсхүл D-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (4) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн туршлагатай байх;
- (5) шугамын агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэх ур чадвараа Даргад амжилттай шалгуулсан байх.
- (6) шугамын агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хугацаанд, зөвшөөрөгдсөн шалгагч-нисгэгчийн сургалтын курсийг амжилттай төгссөн байх.

(b) Аливаа этгээд нь ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тохирох А-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн дадлага туршлагатай байх;
- (3) ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн үүрэг гүйцэтгэх ур чадвараа Даргад амжилттай шалгуулсан байх;

(4) ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц хугацаанд, зөвшөөрөгдсөн шалгагч-нисгэгчийн сургалтын курсийг төгссөн байх.

(с) Аливаа этгээд нь ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшихийн тулд дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

- (1) тохирох, хүчинтэй коммерийн нисгэгчийн, эсхүл түүнээс дээд эрэмбийн нисгэгчийн үнэмлэх эзэмшдэг байх;
- (2) тохирох, хүчинтэй E-Категорийн багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх;
- (3) дараах цагийг багтаасан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн цагийн туршлагатай байх:
 - (i) нийт нислэгийн цаг;
 - (ii) хөлгийн даргын үүрэг гүйцэтгэсэн нислэгийн цаг;
 - (iii) агаараас бордоо цацсан нислэгийн цаг, хэрэв хамааралтай бол;
 - (iv) агаараас шингэн цацсан нислэгийн цаг, хэрэв хамааралтай бол;
 - (v) агаараас мэрэгчийн хор цацсан нислэгийн цаг, хэрэв хамааралтай бол;
 - (vi) нислэгийн зааварчилгаа өгсөн цаг;
- (4) тухайн этгээд нь ХАА-н шалгагч-нисгэгчийн үүргийг гүйцэтгэх чадвараа Даргад амжилттай шалгуулсан байх;
- (5) ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргахаас өмнөх 12 сарын дотор, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад хугацаанд шалгагч-нисгэгчийн зөвшөөрөгдсөн сургалтын курсийг төгссөн байх.

61.903. Зэрэглэл олгох

Хэрэв Дарга, шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмших хүсэлт гаргагч нь 61.901-ийн холбогдох шаардлага хангасан гэж үзвэл, Дарга тухайн хүсэлт гаргагчийн нисгэгчийн үнэмлэхэнд тэмдэглэл хийн зэрэглэл олгох ба тухайн нисгэгчийн дэвтэрт холбогдох шалгагч-нисгэгчийн эрхийн тэмдэглэл хийж болно.

61.905. Эрх, хязгаарлалт

Шугамын агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл

(а) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй шугамын агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь энэ Дүрмээр шаардсан нисгэгчийн үнэмлэх олгох, эсхүл зэрэглэл олгох, эсхүл сунгах, эсхүл үйл ажиллагааны ур чадварын үнэлгээ хийх зорилгоор Даргын олгосон зөвшөөрлийн дагуу дараах гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хүрээнд нислэгийн шалгалт авч болно:

- (1) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл

- (2) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол.

Ерөнхий зориулалтын нисэхийн Шалгагч-нисгэгчийн зэрэглэл

(b) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй ерөнхий зориулалтын нисэхийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь энэ Дүрмээр шаардсан нисгэгчийн үнэмлэх олгох, эсхүл зэрэглэл олгох, эсхүл сунгах, эсхүл үйл ажиллагааны ур чадварын үнэлгээ хийх зорилгоор нисдэг тэрэг болон гэрчилгээжсэн зорчигчийн суудлын багтаамж нь шаардлагатай нисгэгчийн суудлаас гадна 9, эсхүл түүнээс цөөн нисэх онгоцны хувьд, Даргын олгосон зөвшөөрлийн дагуу дараах гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хүрээнд нислэгийн шалгалт авч болно:

- (1) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
- (2) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа, хэрэв тухайн гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг бол; эсхүл
- (3) тухайн нислэгийн шалгалт авахаар Даргын шилжүүлсэн эрх эзэмшдэг этгээдийг үндсэн ажилтнаар, гэрээгээр, эсхүл оролцуулан ажиллуулдаг.

ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл

(ba) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй ХАА-н шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь энэ Дүрмээр шаардсан зэрэглэл олгох, эсхүл сунгах, эсхүл үйл ажиллагааны ур чадварын үнэлгээ хийх зорилгоор Даргын олгосон зөвшөөрлийн дагуу дараах байгууллагын хүрээнд нислэгийн шалгалт авч болно:

- (1) гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа; эсхүл
- (2) гэрчилгээ нь эзэмшигчид тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг ИНД-137-гийн дагуу олгосон ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа; эсхүл
- (3) тухайн нислэгийн шалгалт авахаар Даргын шилжүүлсэн эрх эзэмшдэг этгээдийг үндсэн ажилтан, гэрээгээр, эсхүл оролцуулан ажиллуулдаг.

Хязгаарлагдмал эрхтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл

(c) Энэ зүйлийн (d)-г харгалзан, хүчинтэй хязгаарлагдмал эрхтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэлтэй тухайн эзэмшигч нь Даргын олгосон зөвшөөрлийн эрхийг, тухайн нислэгийн шалгалт авахыг зөвшөөрдөг ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын хүрээнд хэрэгжүүлж болно.

Бүрэн эрхтэй шалгагч-нисгэгчийн зэрэглэл

(d) Аливаа шалгагч-нисгэгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн тулд тухайн эзэмшигч нь ашиглаж байгаа агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй тохирох, хүчинтэй багш-нисгэгчийн зэрэглэл эзэмшдэг байх үүрэгтэй.

(e) Энэ зүйлийн (d)-г үл харгалзан, хэрэв шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигч нь шаардлагатай багийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй бол, хүчинтэй ЭМГ, эсхүл хүчинтэй маягийн зэрэглэл эзэмшихийг шаардахгүй.

61.907. Хүчинтэй байх шаардлага

(a) Тухайн шалгагч-нисгэгч нь өмнөх 24 сарын дотор тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэх ур чадвараа Даргад амжилттай шалгуулснаас бусад тохиолдолд, шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийг тухайн зэрэглэлийн эрхийг хэрэгжүүлэхийг хориглоно.

(b) Шугамын агаарын тээвэрлэгчийн шалгагч-нисгэгчийн зэрэглэл эзэмшигчийн хувьд, энэ зүйлийн (a)-д шаардсан ур чадварын шалгалт нь зөвшөөрөгдсөн нислэгийн дадлагажуурын сегмент, эсхүл нислэгийн сегмент, эсхүл хоёуланг нь багтаасан байх ёстой, хэрэв Дарга шаардсан бол:

- (1) шалгагч-нисгэгчийн шалгалт авах хамгийн хүнд маягийн агаарын хөлөг дээр, эсхүл Даргын шаардаж болох бусад агаарын хөлөг дээр;
- (2) ИНД-121, 125 эсхүл ИНД-135-ын шаардлагын дагуу, тухайн зорьж байгаа эрхтэй хамааралтайг нь.

(c) Шаардсан өдрөөс өмнө 60 хоногийн дотор энэ зүйлийн (a)-д шаардсан шалгалтыг амжилттай өгсөн нисгэгчийг тухайн шалгалтыг шаардсан хугацаанд нь өгсөнд тооцно.

61.909. Мөрдөгдөж байгаа дүрмийн заалтыг хүчингүй болгох болон хадгалах

(a) 2002 онд хүчинтэй болсон ИНД-61 болон түүний нэмэлт өөрчлөлтүүд нь энэхүү шинэчлэлтээр хүчингүй болж, солигдоно.

(b) Хэрэв дараах бичиг баримт нь шинэчилсэн ИНД-61-ийг 2018 оны 12 сарын 31-нээс мөрдөж эхлэхээс өмнө гарсан бол, хүчинтэй хэвээр байна:

- (1) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ИНД-61-ийн дагуу олгосон бүх үнэмлэх, зэрэглэл болон бусад нисэхийн баримт бичиг;
- (2) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ИНД-61-ийн дагуу нисэхийн баримт бичиг эзэмшигчийн хэрэгжүүлж байгаа бүх эрх, хязгаарлалт;
- (3) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ИНД-61-ийн дагуу зөвшөөрөгдсөн бүх бичгийн шалгалтын, эсхүл нислэгийн шалгалтын дүн болон кредит;
- (4) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ИНД-61-ийн дагуу зөвшөөрөгдсөн бүх нислэгийн шалгалтын дүн;
- (5) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ИНД-61-ийн дагуу нисгэгчийн дэвтэрт бичсэн бүх нислэгийн цагийн бичилтүүд;

- (6) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө, ИНД-61-ийн дагуу бүх нислэгийн туршлага хадгалсан тухай болон нислэгийн үнэлгээ хийсэн тэмдэглэл;
- (7) 2018 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ИНД-61-ийн дагуу олгосон, эсхүл хүсэлт гаргасан бүх маягтууд.

--oOo--